



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2020 • 03 • № 43

Б.ЛХАГВАСҮРЭН:

МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ
ЗӨӨЛРҮҮЛЭХ НЬ ЭДИЙН
ЗАСГИЙГ СЭРГЭЭХЭД
ДЭМЖЛЭГ БОЛНО

Н.УРГАМАЛСУВД:

"КОВИД-19"-ИЙН
НӨЛӨӨГӨӨР ЭДИЙН
ЗАСГИЙН ӨСӨЛТ
ХАМГИЙН БАГАДАА
1 НЭГЖ ХУВИАР
СААРНА



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС:
БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН **ЧОН ГАРТААМ ХӨӨРӨГ**

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

БОДЛОГЫН ХҮҮГ БУУРУУЛАХ, ТӨГРӨГИЙН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХУВИЙГ БАГАСГАХ БОЛОН БОДЛОГЫН ХҮҮНИЙ КОРИДОРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

ДУГААР: 2020 | 01
ОГНОО: 2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН 11-НИЙ ӨДӨР

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргалаа.

Жилийн инфляц 2020 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 5.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.0 хувь байна. Эдийн засгийн өсөлт саарах хандлага үргэлжилж, эрэлтийн шалтгаантай инфляц тогтвортой байх төлөвтэй байна. Харин импортын хүнсний зарим бүтээгдэхүүний хангалт удаашрах тохиолдолд нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын хэлбэлзэл үүсч болзошгүй.

Ковид-19 вирусийн тархалттай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж байгаагаас гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурч, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил сулран, эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах эрсдэлийг бий болгож байна. Цаашид эдийн засагт үзүүлэх нөлөө нь Ковид-19 вирусийн тархах цар хүрээ болон үргэлжлэх хугацаа, вирусийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс ихээхэн хамаарахаар байна. Экспортын орлого буурах эрсдэл нэмэгдэж байгаа хэдий ч хэрэглээний импорт агших хандлага үргэлжилж, дэлхийн зах зээл дээр нефтийн үнэ огцом буурсан нь төгрөгийн ханшинд үзүүлэх дарамтыг зөөлрүүлэхээр байна.

Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлс болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкнуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор бодлогын багц шийдвэр гаргав.

Мөнгөний бодлогын хорооны энэ удаагийн шийдвэр нь инфляцын зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байна.

Хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



05

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ:

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
ОХУ-ААС
МОНГОЛ УЛСАД
СУУГАА ОНЦ
БӨГӨӨД БҮРЭН
ЭРХТ ЭЛЧИН
САЙДЫГ ХҮЛЭЭН
АВЧ УУЛЗЛАА



06

ЯРИЛЦЛАГА:

Б.ЛХАГВАСҮРЭН:


МӨНГӨНИЙ
БОДЛОГЫГ
ЗӨӨЛРҮҮЛЭХ
НЬ ЭДИЙН
ЗАСГИЙГ
СЭРГЭЭХЭД
ДЭМЖЛЭГ БОЛНО



15

БАЙР СУУРЬ:

ЭДИЙН ЗАСАГЧ
Г.БУМЧИМЭГ:
БОДЛОГЫН
АСУУДАЛ ДЭЭР
БОДОЛТОЙ8
БОЛГООМЖТОЙ
ХАНДАХ ХЭРЭГТЭЙ
БОДЛОГО



28

ДЭЛХИЙН
ЭДИЙН ЗАСАГ:

ДЭЛХИЙН
УЛСУУДЫН
МӨНГӨНИЙ
БОДЛОГОД
ГАРСАН
ӨӨРЧЛӨЛТҮҮД



21

НИЙТЛЭЛ

МОНГОЛЫН
ХӨГЖЛИЙН
ЗАМ /Сүргамж,
Сорилт, Боломж/



24

БАНКИР:

Л.АМАР:

“КОВИД-19”-ИЙН
НӨЛӨӨ
БАНКНЫ
САЛБАРТ ХЭД
ХЭДЭН
СУВГААР
МЭДРЭГДЭЖ
БАЙНА.



16

МОНГОЛ БАНК ЮУ
ХИЙДЭГ ВЭ?

Н.УРГАМАЛСУВД:

“КОВИД-19”-ИЙН
НӨЛӨӨГӨӨР
ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТ
ХАМГИЙН
БАГАДАА
1 НЭГЖ ХУВИАР
СААРНА



36

САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ:

ЦАХИМ
ТӨЛБӨР
ТООЦООНЫ
ХЭРЭГЛЭЭ

2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

2020.03.04

ЗАСГИЙН ГАЗРААС “АЛСЫН ХАРАА-2050” БАРИМТ БИЧГИЙГ МОНГОЛБАНКАНД ГАРДУУЛЛАА

Уг баримт бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Монгол Улсын сайд Л.Оюун-Эрдэнэ Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд гардууллаа. Сайд Л.Оюун-Эрдэнэ баримт бичгийг гардуулах үеэрээ хөгжлийн урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд Засгийн газар Төв банк болон бусад мэргэжлийн байгууллагууд, улс төрийн намуудтай нягт

хамтран ажиллах хэрэгтэй. Төв банкны мөнгөний бодлого болон Засгийн газрын хөрөнгө оруулалтын бодлогууд харилцан уялдаа холбоотой, нэгдсэн чиг баримжаатайгаар хэрэгжих нь зүйтэй гэсэн юм. Үүний дараа Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Монголбанкнаас баримталж буй бодлогын талаар танилцуулахын хамт Коронавирусийн эрсдэлтэй холбоотойгоор өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа энэ үед төв банк ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ЗГ, УИХ-тай хэрхэн хамтран ажиллах талаар санал солилцлоо.

2020.03.17

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн I улирлын ээлжит хуралдаан болж, Монголбанкнаас банкны салбарт авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар хэлэлцлээ. Үүнд: санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид буюу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа

эрхлэгчийн үйл ажиллагааг хянаж, зохицуулах чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хэлэлцлээ. Мөн төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний тайлан, шинэ төрлийн корона вирусийн улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тус тус хэлэлцэв.

2020.03.18

ЗЭЭЛИЙН АНГИЛАЛ, ЭРГЭН ТӨЛӨЛТӨД ТҮР ХУГАЦААГААР ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

"Ковид-19"-ийн тархалттай холбоотойгоор Монголбанкнаас зохих журмууддаа зохицуулалт хийж, түр хугацаагаар буюу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хэрэгжүүлэхээр




мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлэв.

болов. Эдгээр зохицуулалт нь "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэн зээлийн эргэн төлөлтөө хийхэд хүндрэл учирч буй зээлдэгчид нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ОХУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

2020.03.19



байгаа нөхцөл байдал, өдгөө авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний талаар мэдээлэл өглөө. Мөн Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Мөнгөний бодлогын хороо болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс гарсан шийдвэрүүдийг танилцуулахын зэрэгцээ хоёр талын банкны секторын хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Монголбанкны холбогдох удирдлагуудын хамт ОХУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд ноён И.К.Азизов болон албаны бусад төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтын эхэнд, Монгол Улсын макро эдийн засгийн төлөв, шинэ төрлийн Коронавирусийн дэгдэлтийн улмаас үүсээд

ЦАХИМ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД УРИАЛЖ, БАГА ДҮНТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ШИМТГЭЛИЙГ БУУРУУЛЛАА

2020.03.31



гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20-100 хувь буурууллаа. Тус арга хэмжээг Ариг банк, Богд банк, Голомт банк, Капитрон банк, Кредит банк, Төрийн банк, Тээвэр хөгжлийн банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Хаан банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк, Чингис хаан банк тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монголбанкнаас олон улсыг хамарсан "Ковид-19" цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор иргэдийг банкны салбар, тооцооны төвөөр үйлчлүүлэхээс татгалзан, төлбөр тооцоогоо интернет банк, мобайл банкны үйлчилгээ ашиглан хийхийг уриалалаа. Энэхүү уриалгын хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн



Б.Лхагвасүрэн:

МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ЗӨӨЛРҮҮЛЭХ НЬ ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХЭД ДЭМЖЛЭГ БОЛНО

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭНТЭЙ ЯРИЛЦЛАА.

Мөнгөний бодлогын хүүг 1 нэгж хувиар буулгаж 10 хувь болгох шийдвэр гаргасан нь эдийн засгийн нөхцөл байдалтайгаа хэрхэн уялдуулж байгааг юуны өмнө тайлбарлана уу?

"Ковид-19" цар тахлын тархалттай холбоотойгоор дэлхий дахинд тодорхой бус байдал нэмэгдэж, гадаад болон дотоод эдийн засгийн идэвхжил суларч байгаа өнөөгийн нөхцөлд Монголбанк банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн идэвхжлийг дэмжих бүхий л боломжуудыг судалж, шаардлагатай арга хэмжээг авч байна. Эдийн засгийн өсөлт сүүлийн 5 улирал дараалан буурч, 2020 эхний хагаст ч үргэлжлэн саарахаар байна.

Уул уурхайн салбар 2019 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар буурсан нь 2019 оны өсөлт хүлээлтээс доогуур гарахад голлон нөлөөлсөн. Энэ онд цар тахлын нөлөөгөөр уул уурхайн салбараас гадна уул уурхайн бус салбарын өсөлт саарахаар байна. Тухайлбал, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт саарах нь тээврийн салбарт, хөл хорио нь аялал жуулчлал,

нийтийн хоол, зочид буудал, бусад үйлчилгээ болон худалдааны салбарт сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ бүтээгдэхүүний цэвэр татварын орлого багасахаар байна.

Дотоод эрэлтийг тодорхой хэмжээнд дэмжих, эдийн засгийн идэвхжил сэргэх үед зээлийн хүүний харьцангуй таатай нөхцөлийг бий болгоход энэхүү бодлогын арга хэмжээ дэмжлэг болно. Хамгийн гол нь инфляцын түвшин сүүлийн жил хагасын хугацаанд буурч, 6 орчим хувьтай байгаа нь энэ боломжийг олгож байна. Мэдээж дунд хугацаандаа эдийн засгийн гадаад тэнцвэр хангагдах нөхцөлд иргэдийн хэрэглээ нэмэгдэж, хувийн секторын хөрөнгө оруулалтын өртөг буурснаар эдийн засгийн идэвхжил нэмэгдэнэ гэж төсөөлж байна.

Монголбанк бодлогын хүүг 0.5 нэгж хувиар бууруулах саналыг оруулна гэж байсан боловч 1 нэгж хувиар буурууллаа, бодлогын хүүний өөрчлөлт инфляц болон гадаадын валютын ханшинд дарамт болох вий гэдэг болгоомжлол байдаг.

2020 оны эхний 2 сард экспорт 30 хувиар, импорт 10 хувиар буурч, нийт гадаад худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс 21 хувиар бага буюу 1,521 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 235 сая ам.доллараар буурсан хэдий ч гадаад худалдааны тэнцэл 21 сая ам.долларын ашигтай гарлаа. "Ковид-19"-ийн нөлөөгөөр манай нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны экспорт түр зогссоны зэрэгцээ Хятадын эдийн засгийн өсөлт сааран, дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс, төмрийн хүдрийн үнэ буурах хандлагатай байгаа нь экспортод сөргөөр нөлөөлж байна. Гэхдээ цаашид экспортоо сэргээх нь хамгийн чухал бөгөөд Засгийн газрын зүгээс эхний алхмууд хийгдэж эхлээд байна.

Вирусийн халдварын эсрэг аюулгүй байдлыг сайн хангасны үндсэн дээр нүүрс болон газрын тосны тээвэрлэлтийг эхлүүлэх гэж байгаа нь зөв алхам гэж харж байгаа. Түүнчлэн түүхий эдийн зах зээлд бий болсон алтны үнийн өсөлт, нефтийн үнийн бууралт, Оюу толгойн хөрөнгө оруулалт валютын урсгалд дэмжлэг үзүүлнэ. Тухайлбал, одоогийн байдлаар нефтийн үнэ 45%-иар буураад байна. Өнгөрсөн жил нефтийн үнэ дунджаар 64-65 ам.доллар байхад Монгол Улсын бензин болон дизель түлшний бүлэг барааны импортын төлбөр 1.2 орчим тэрбум ам.доллар байсан.

Энэ жилийн хувьд нефтийн гэлтгүй нийт импорт ялангуяа хөрөнгө оруулалтын импорт үргэлжлэн саарна гэж хүлээж байна. Төв банкны гадаад валютын нөөц манай улсын импортын 9 сарын хэрэгцээг хангахаар байгаа бөгөөд энэ нь олон улсын дундажтай харьцуулахад харьцангуй өндөр дүн юм. Мөн энэ онд төлөгдөхөөр хүлээгдэж байгаа томоохон өр төлбөрүүдийг валютын нөөц болон ханшид дарамтгүйгээр шийдэхээр ажиллаж байна.

Энэ удаагийн бодлогын шийдвэр хүү өөрчлөхөөс гадна банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан. Энэ арга хэмжээ бодит эдийн засагт яг ямар үр нөлөө үзүүлэх вэ?

Энэхүү бодлогын арга хэмжээ нь банкнуудын зээлд гаргах боломжтой эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах, улмаар эдийн засаг дахь санхүүгийн зуучлалыг дэмжих үндсэн зорилготой.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНООС БАНКНУУДЫН ТӨГРӨГИЙН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРИЙН ХУВЬД ТОГТООСОН ЗААВАЛ БАЙЛГАХ НӨӨЦИЙН ХУВИЙГ ОДОО МӨРДӨГДӨЖ БУЙ 10.5 ХУВИАС 8.5 ХУВЬ БОЛГОН БУУРУУЛАХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАЛАА.

Ингэснээр системийн хэмжээнд банкуудын 324 тэрбум төгрөг заавал байлгах нөөцөөс чөлөөлөгдөж байна. Бодлогын хүүтэй харьцуулахад тус арга хэмжээний нөлөөлөл нь эдийн засаг болон санхүүгийн системд илүү хурдан илэрдэг. Тэр утгаараа өнөөдрийн энэ төвөгтэй нөхцөлд шууд нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэн хосолмол арга хэмжээ авч байна гэж ойлгож болно.

"Ковид-19"-ийн нөлөөнөөс болж ерөнхийдөө эдийн засгийн идэвхжил буурсан нь банкнуудад зээлийн эргэн төлөлтөд эрсдэл учруулж болохоор нөхцөл байдал үүсч мэдэхээр байна шүү дээ. Иймд энэ эрсдэлээс сэргийлсэн бодлогод Мөнгөний бодлогын хороо хэрхэн анхаарсан бэ?

Дээрх 2 арга хэмжээн дээр нэмээд хүүний коридорын өргөнийг мөнгөний бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувь байхаар шинэчлэн тогтоолоо. Ингэснээр бодлогын хүүний коридорын дээд хязгаар буюу Төв банкны овернайт репо санхүүжилтийн хүүг нэмэлт 1 нэгж хувиар буюу нийт бодлогын хүүний бууралтыг оролцуулан тооцвол 2 нэгж хувиар буурууллаа. Энэхүү арга хэмжээний гол зорилго нь Төв банкны санхүүжилтийн өртгийг бууруулж, зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалсан хөрвөх чадварын болзошгүй эрсдэлээс банкны системд учирч болох санхүүгийн дарамтыг бууруулах зорилготой.

Энэ үед ихэнх Төв банк бодлогын хүүгээ бууруулж байгаагийн үндсэн шалтгаан нь санхүүгийн системийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглүүлж улмаар санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжилж, санхүүжилтийн өртөг нь бага байлгахад дэмжлэг болохыг зорьж байна.

АНУ-ын Холбооны Нөөцийн банкны удирдлагын олон нийтэд өгсөн мэдээлэлд ч маш тодорхой тайлбарласан байгаа. Бодлогын хүүг бууруулснаар вирусийн тархалтыг зогсоохгүй ч санхүүжилтийн өртөг зардлыг бууруулснаар эдийн засагт дэмжлэг үзүүлнэ гэж мэдээлсэн.

Бодлогын шийдвэр гарснаар нааштай өөрчлөлтүүд гарахаар болж байгаа хэдий ч хорио цээрийн дэглэм тогтоосноор бизнесийн үйл ажиллагаа саарч, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарынханд маш хүнд тусч байна. Төв банк, банкны салбарын зүгээс тодорхой ямар нэг дэмжлэг үзүүлж болох уу?

Төв банк буюу Монголбанкны тухай хуулиар тухайлсан хувь хүн, хуулийн этгээд, салбарыг онцгойлон зээл, санхүүжилт олгохыг хориглосон байдаг. Бусад улс орнуудын Төв банк ч ийм л хуулийн зохицуулалтад үйл ажиллагаа явуулж байгаа. Төв банкнууд ийм эх үүсвэр, тийм санхүүжилт олгохоор боллоо гэдэг нь бүгд л аль нэг банк, санхүүгийн зуучлагчаар дамжин эцсийн зээлдэгчид буюу бизнес эрхлэгчдэд очно.

Эх үүсвэр санхүүжилт хэр хүртээмжтэй байх, санхүүжилтийн зардал хэр хэмжээтэй байх гэдэг нь Төв банкны бодлогын шийдвэрээс тодорхой харагдаж байгаа. Төв банк мөн хуулиараа банкны дотоод үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцон бүтээгдэхүүн үйлчилгээний хүү, шимтгэлийн үнэ хэмжээг тогтоох, бууруулах, зогсоохыг хориглосон байдаг.

Энэ утгаараа зээл хүүтэй холбоотой асуудалд зөвлөмж чиглэл өгөхөөс өөрөөр шууд нөлөөлөх, оролцох эрхгүй. Өнгөрсөн долоо хоногт Монголбанкны удирдлага Монголын банкны холбооны төлөөлөлтэй нэлээд өргөн бүрэлдэхүүнээр уулзан, өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэмийн үед санхүүгийн системийн хэвийн ажиллагааг хангахад хэрхэн хамтарч ажиллах талаар санал солилцсон.

Мөн зээл төлөлтийн хуваарь зөрчигдөх, үндсэн өр, хүү төлөлттэй холбогдуулан ямар арга хэмжээ авч болох, зохицуулагчийн зүгээс үүссэн нөхцөл байдалтай нийцүүлэн холбогдох хууль журам, эрх зүйн баримт бичигт ямар өөрчлөлт оруулах боломжтой талаар зөвлөлдсөн. Өнөөдрийн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан банкнуудын зүгээс харилцагч бизнес эрхлэгчдийг түр хугацаанд торгууль, алдангиас чөлөөлөх, хорио цээрийн дэглэмийн үед зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах боломжтой талаар зөвлөж, зохицуулагчийн зүгээс нөхцөл байдалтай уялдуулан журам заавраа зөөллөх боломжтойг уламжилсан.

Таны бодлоор цаашид анхаарах гол асуудал юу вэ?

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэр нь цогц шийдвэр гэдгийг өмнөх хариултуудаас анзаарсан байх. Хэдийгээр улс орнуудын Төв банкнууд мөнгөний бодлогоор эдийн засгийг дэмжих шийдвэр гаргаж байгаа хэдий ч хямралын суурь шалтгаан эмчлэгдэхгүй бол цаашид хэчнээн мөнгөний бодлогыг өөрчлөөд ч үр дүн хязгаартай гэдгийг бид ойлгох ёстой.

"Ковид-19" цар тахлын тархалт буурч, эмчилгээ үр дүнтэй болсноор иргэдийн айдас арилж, хэвийн ажил амьдрал эхэлнэ. Ингэснээр хөл хорио тавигдаж, дотоод борлуулалт нэмэгдэж, гадаад худалдаа, бизнесүүд сэргэнэ. Төгрөгийн үнэ цэнийг хадгалах, ханшийг тогтвортой байлгах чиглэлд тодорхой арга хэмжээ авах талаар судалгаа, тооцоо хийж байгаа, удахгүй шийдвэрүүд гаргана. Тухайлбал, валютаар хийгдэж байгаа банкны бүтээгдэхүүн үйлчилгээ, валютын харилцах хадгаламжийн дансыг цэгцлэх, хадгаламжийн даатгалд хамруулах эсэх зэрэг хууль эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх зэрэг ажлууд хийгдэнэ.


Ярилцсанд баярлалаа.

МОНГОЛБАНКНЫ БОДЛОГЫН ХҮҮ

Төв банкуудын үндсэн зорилт болох үнийн тогтвортой байдлыг хангахын тулд ашигладаг гол арга хэрэгслүүдийн нэг нь бодлогын хүү юм. Монголбанкны хувьд, энэ нь төв банкны үнэт цаасны хүү болдог. Монголбанкны Мөнгөний бодлогын хороо жилд хамгийн багадаа 4 удаа хуралдаж (улирал бүр ээлжит хуралдаан болох ба ээлжит бус хуралдааныг тухай бүр зарлан хуралдуулж болно), бодлогын хүүг өөрчлөх эсэх шийдвэрийг гаргадаг.



Бодлогын хүү, хувиар



Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргав.



Төв банк хэзээд бусдаас авсан эх үүсвэрээ эргүүлж төлөх чадвартай гэдэг утгаараа бодлогын хүүг эрсдэлгүй хүү ч гэж үздэг. Энэхүү эрсдэлгүй хүүг харгалзаж зах зээл дээрх бусад арилжааны хүү тогтдог учир бодлогын хүүг хөтөч хүү, эсвэл жишиг хүү гэж нэрлэх нь бий.

Бодлогын хүү өндөр үед арилжааны банкууд эрсдэлтэй зээл олгож, эрсдэл үүрэхийн оронд төв банканд мөнгөө найдвартай хадгалуулах, эсвэл зөвхөн өндөр хүүтэй зээл авч чадах зээлдэгчид л арилжааны зээл олгох нь түгээмэл. Улмаар эдийн засагт нийлүүлэгдэх зээлийн хэмжээ хумигдана.

Харин бодлогын хүү буурах үед банкууд мөнгөө төв банкинд хадгалуулснаас иргэд, компаниудад зээлэх нь ашигтай тул эдийн засаг руу орох мөнгөний урсгал нэмэгддэг.



Бодлогын хүүг өөрчлөх замаар төв банкууд эдийн засагт эргэлдэж буй мөнгөний нийлүүлэлтийг удирдаж, эдийн засаг хэт халах эсвэл удаашрахаас сэргийлж, эцсийн дүндээ үнийг тогтвортой байлгахыг зорьдог. Энэ нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад төв банкны зүгээс оруулах чухал хувь нэмэр юм.

Бодлогын хүү нь ийнхүү арилжааны банкуудын зээлээс гадна, зах зээл дээрх хөрөнгийн үнэ, валютын ханш, зах зээлд оролцогчдын хүлээлт зэрэг бусад сувгуудаар дамжин эдийн засагт тодорхой цаг хугацааны хоцрогдолтойгоор нөлөөлдөг. Хамгийн хүчтэй нөлөө нь бодлогын хүүг өөрчилснөөс 4-6 улирлын дараа илэрч, харин нөлөө нь бүрэн арилтлаа 2-3 жил шаардагдах тохиолдол ч бий. Иймд Мөнгөний бодлогын хороо Бодлогын хүүгээ өөрчлөхдөө үргэлж урагш харж, ирээдүйд чиглэсэн шийдвэр гаргахыг зорьдог.

МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС...



Мөнгөний бодлогын хороо гуравдугаар сарын 11-нд хуралдаж шийдвэрээ гаргасан бөгөөд Мөнгөний бодлогын мэдэгдлийг танилцуулах хэвлэлийн хурлаа цахимаар хийлээ. Тус хуралд Мөнгөний бодлогын хорооны гишүүн Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэг, орон тооны бус гишүүн УИХ-ын даргын эдийн засгийн зөвлөх Ц.Мөнхбаяр, СЭЗИС-ийн экономиксийн тэнхимийн профессор Ц.Батсүх, Монгол Улсын Их Сургууль, Эдийн засгийн тэнхимийн профессор Ч.Хашчулуун нар мэдээлэл өгсөн юм. Тус мэдээллийг толилуулъя.

О.Эрдэмбилэг:

Манай улсын эдийн засаг гол төлөв гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр сүүлийн хэдэн улиралд нэлээд саараад байна. Инфляц 2020 оны нэгдүгээр сарын байдлаар улсын хэмжээнд 5.6 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.0 хувьтай гарсан. Коронавирустэй холбоотойгоор эдийн засгийн идэвх дахин саарах хандлага үргэлжлэхээр байна. Үүнтэй холбоотойгоор эрэлтийн шалтгаантай инфляц тогтвортой байх төлөвтэй хэдий ч, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцад хэлбэлзэл үүсэж

болзошгүй байна. КОВИД вирусийн тархалт эдийн засагт нөлөөлж байгаа сувгуудын хувьд худалдааны суваг, түүхий эдийн суваг, тайлан балансын сувгаар орж ирж байна. Цаашид вирусийн тархах цар хүрээ, үргэлжлэх хугацаа, улс орнуудын вирусийн эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс их зүйл шалтгаалахаар байна. Одоогийн байдлаар энэ нөхцөл байдал ид өрнөж байгаа учраас тодорхой бус байдал их байна. Мөнгөний бодлогын хороо хуралдаж, эдийн засгийн тогтвортой

байдал, банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилтын хүрээнд хэд хэдэн арга хэмжээг авлаа.

Нэгдүгээрт, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх шийдвэр гаргаад байна. Банкуудын төгрөгийн заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоохоор боллоо. Бодлогын хүүгийн коридорыг +2 нэгж байсныг нарийсгаж, +1 болгох шийдвэр гаргалаа.

Ч.Хашчулуун:

Мөнгөний бодлогын хорооноос гаргасан шийдвэрийн гол утга нь эдийн засгийн идэвхжлийг дэмжих чиглэлтэй. Сүүлийн саруудад эдийн засгийн байдал тодорхой хэмжээгээр муудаж, эдийн засгийн өсөлт буурах төлөвтэй байсан. Энэ арга хэмжээгээр эдийн засгийг идэвхжүүлэх, банкны системд байгаа төгрөгийн эх үүсвэрийн өртгийг бууруулж, зээлийн хамрагдалт, хүртээмжийг сайжруулах зорилготой юм. Энэ утгаараа Монголбанкны зүгээс эдийн засгийн хүндрэлтэй байдлаас гарахын тулд авч байгаа нэлээд шийдэмгий арга хэмжээ болж байна.

Ц.Мөнхбаяр:

МБХ-ны энэ удаагын шийдвэр нь зөвхөн бодлогын хүүг бууруулах бус цогц арга хэмжээ юм. Мөнгөний бодлогын нөлөөллийг сайжруулах, богино болон дунд хугацаанд үйлчлэх үйлчлэлийг илүү хүчтэй болгох, гэнэтийн шокийн эсрэг арга хэмжээ юм. Бодлогын хүүгийн коридорыг нарийсгаж байгаа нь банкуудын төлбөрийн чадварыг сайжруулах, эх үүсвэрийн өртгийг бууруулах зорилготой юм. Энэ нь мөнгөний бодлогын бусад шийдвэртэйгээ нийлээд, бодлогын үр нөлөөг сайжруулахад чухал ач холбогдолтой.

Ц.Батсүх:

Гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан эдийн засгийн агшилттай үед эрэлтийн талын инфляцын дарамт багасч байна. Энэ үед эдийн засгийн идэвхжлийг сайжруулах зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар буурууллаа. Нөгөө талдаа банкуудын тогтвортой байдлыг хангах зорилгоор хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлж, заавал байлгах нөөцийн хувь хэмжээг буурууллаа. Түүнчлэн пассивын долларжилтыг бууруулахад анхаарч, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах шийдвэр гаргалаа.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2020 оны 03 дугаар сар

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсэр талаас)




- M2 мөнгөний жилийн өсөлт **5.2%** болж, үлдэгдэл **20.6** их наяд төгрөгт хүрэв. Жилийн өсөлтийн **4.4** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **3.1** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **0.2** нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, **-0.1** нэгж хувийг төгрөгийн харилцах, **-2.4** нэгж хувийг гадаад валютын харилцах бүрдүүлсэн байна.




- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **17.3** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **3.3** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Зээл, зээлийн чанар



- Банкуудын зээлийн үлдэгдэл **17.2 их наяд төгрөг** (төгрөгийн зээл **15.3** их наяд, гадаад валютын зээл **1.9** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **4.1%-**иар буурчээ.
- Нийт зээлийн **10.7%** нь чанаргүй, **6.0%** нь хугацаа хэтэрсэн зээл байна.

2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.3. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь




Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



- Өмнөх оны мөн үеэс банкуудын зээлийн үлдэгдэл **0.5%-**иар өсч **17.2** их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл **3.7%-**иар буурч **8.6** их наяд төгрөгт,
- Хувийн байгууллагын **5.5%-**иар өсч **8.4** их наяд төгрөгт хүрчээ.
- Нийт зээлийн **11.1%-**ийг, иргэдийн зээлийн **1.4%-**ийг, хувийн байгууллагын зээлийн **20.7%-**ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тухайн сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд 665 зээлдэгчид 54.5 тэрбум Т-ийн ипотекийн зээл шинээр олгосноос 31.9% нь хөтөлбөрийн, 68.1% нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх жилээс 1.7 нэгж хувиар, өмнөх сараас 0.7 нэгж хувиар тус тус буурчээ.

4. Хүү

Зураг 4.1. Шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. Шинээр олгосон зээлийн хүү




- Иргэдээс татсан Т-ийн хадгаламжийн ЖДХ 10.8%, хувийн байгууллагаас татсан Т-ийн хадгаламжийн ЖДХ 7.8% байна.
- Иргэдэд шинээр олгосон Т-ийн зээлийн ЖДХ 17.3%, хувийн байгууллагад олгосон Т-ийн зээлийн ЖДХ 16.9% байна.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 2 сар /урьдчилсан/



БАНКУУДЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАЛААРХ ТӨСӨӨЛӨЛ

Зураг 6.7. Эдийн засгийн төлөвийн таамаглал



Зураг 6.8. М2 мөнгөний өсөлтийн таамаглал



Зураг 6.9. Зээлийн төлөвийн таамаглал



Зураг 6.10. Зээлийн хүүний таамаглал



Эх сурвалж: Банкуудын макро эдийн засгийн талаарх төсөөлөл 2020 оны 2 сар, Монголбанк

БОГД ЖАВЗАНДАМБА ХУТАГТЫН

Үн Тармагт Хөөрөг



ХІХ ЗУУН

ЖИН: 85.3 ГР


ӨНДӨР: 7.5 CM, 57.4 X 40 X 28.5 MM

БӨӨРӨНДӨӨ ДӨРВӨН ШИРХЭГ АЛТНЫ ЖИЖИГХЭН ИЛЭРЦТЭЙ, ХАГАС ТУНГАЛАГ ЦАГААН БОЛОН
УЛААН ЧУЛУУ ХОЛИЛДСОН УХМАЛ ХӨНДИЙ ЗАСАЛТТАЙ ЧУЛУУН ХӨӨРӨГ.



Эдийн засагч Ч.ХАПЧУЛУУН: Бодлогын хүү эдийн засгийг удирддаг чухал хөшүүрэг. Эдийн засгийн өсөлт сүүлийн үед саарсан. Сүүлийн 5 сард өсөлтийн хурд мэдэгдэхүйцээр буурах хандлагатай байна. Мөн дэлхий даяар Коронавирус тархаж, эдийн засгийн байдал хүндэрсэн үед эдийн засгийг тодорхой хэмжээгээр дэмжих, хурдыг сааруулахгүй байх нь чухал байна. Монголбанкны хувьд 0.5-1 нэгж хувиар бодлогын хүүг бууруулах саналыг оруулсан. Мөнгөний бодлогын хорооны гишүүд ярилцаж байгаад, эдийн засгийг дэмжих нь чухал байгаа учраас бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулахаар шийдвэрлэсэн. Энэ нь өөрөө мөнгөний бодлогын хувьд томоохон шийдвэр байгаа юм. Хоёрдугаарт, төгрөгийн заавал байлгах нөөцийг бууруулснаар эдийн засагт нэлээд хэмжээний төгрөгийн санхүүжилт шинээр гарах боломжийг нэмэгдүүлээ.

Эдийн засагч Г.БУМЧИМЭГ: Бодлогын хүүг бууруулсан шийдвэр нь эдийн засагт тодорхой хугацааны дараа нөлөөлнө. Магадгүй жил орчмын дараагаас хүчтэй нөлөөллөө үзүүлж эхэлнэ. Тэгэхээр үүнд хугацаа шаардлагатай. Харин заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулсан нь эдийн засагт харьцангуй богино хугацаанд нөлөөлөх боломжтой. Төв банкны шийдвэрийн хувьд өнгөрсөн жил хэрэглээний зээлд макро зохистой бодлогын арга хэмжээ авсан. Энэ нь үр дүнгээ өгч, хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулсан нь өнөөгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг даван туулахад томоохон дэмжлэг болохоор байна. Дэлхийн ихэнх улс орнуудад бодлогын хүүг огцом бууруулж байна, Монгол Улс төдийлөн дорвитой арга хэмжээ авахгүй, бодлогын хүүг томоохон хэмжээгээр бууруулахгүй байна гэх шүүмжлэл бий. Үүнд хариулахад, өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа улс хоёр эрс ялгаатай. Хөгжиж байгаа улсуудын хувьд өрийн хямралд орох эрсдэлтэй байна. Ийм нөхцөлд нэлээд бодолтой, болгоомжтой хөдлөх хэрэгтэй. Төгрөгийн хэт тэлэх бодлого эрсдэл авчирч болно.



МБХ-ны гүйцэтгэх захирал Л.АМАР Заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар бууруулсан. Арилжааны банкууд Монголбанканд ойролцоогоор 1.5 орчим их наяд төгрөгийг заавал байлгадаг. Үүнийг бууруулснаар 320 орчим тэрбум төгрөгийг “Та нар эргүүлээд авч болно” гэж өгч байгаа юм. Үүнээс гадна бодлогын хүүг 1 нэгж хувиар буурууллаа. Энэ нь зээлийн хүүг бууруулахад шууд нөлөөлөхгүй. Хэрвээ зээлийн хүүг бууруулъя гэвэл урт хугацаанд, шат дараатай арга хэмжээ авч байж, үр дүн нь гардаг. Заавал байлгах нөөцөөс 300 тэрбум төгрөг суларч байна гэдгийг системийн хувьд авч үзвэл дахин санхүүжүүлэх шаардлагатай болсон, хүндрэлд орсон зээлүүдэд дэмжлэг үзүүлэх байх. Эдийн засаг Коронавирусийн асуудлаас болж, зээл олголт хумигдсан байна. Эдийн засгийн цусны эргэлтийг дэмжих бодлогын шийдвэр хэрэгтэй байна. Үүнд төр засгийн зүгээс дэмжлэг хэрэгтэй. Төсвийн зүгээс энэ тал дээр дэмжлэг үзүүлэх нөөц бололцоо хангалттай байгаа гэж бодож байна.

Эдийн засагч Н.Энхбаяр: Төв банкны бодлогын хүү нь зах зээлд хэр үр дүнтэй нөлөөлөдг арга хэрэгсэл вэ гэдгийг бид анхааралтай авч үзэх ёстой. Өндөр хөгжилтэй болон хүчирхэг эдийн засагтай, банкны тогтолцоо сайн хөгжсөн улс орнуудад 100 гаруй жилийн туршид хэрэглэж тогтсон арга хэрэгсэл манай улсад адил үр дүн үзүүлэх үү гэдэг нь эргэлзээтэй асуудал. Сүүлийн 10 жилийн хугацаанд мөнгөний бодлогын хүүг нэмэгдүүлсэн, бууруулсан үр нөлөөлөл, түүнд хийсэн судалгааг эргэн авч үзэх ёстой. Тэр тусмаа өнөөгийнх шиг дэлхийн зах зээл бүхэлдээ гацаанд орсон, улс хоорондын худалдаа 80-90 гаруй хувиар буурч байгаа нөхцөлд, эрэлт ба нийлүүлэлтийн аль аль талд хямрал үүсч байхад манай улсад зөвхөн Төв банкны бодлогын хүүний өөрчлөлтөөр гайхалтай үр дүн гарна гэж хүлээх хэрэггүй. Бүх өвчнийг эдгээдэг шидэт эм байдаггүй, “бүх хүнд таардаг нэг хэмжээтэй хувцас гэж байдаггүй” гэдэгтэй адил мөнгөний бодлогын арга хэрэгсэл гадаад, дотоод орчин нөхцөлөөс хамаарч гарах үр дүн өөр өөр л байдаг. Манай улсын тухайд үүсч буй хүндрэл, хямралыг төсвийн болон мөнгөний бодлогоор шийдвэрлэж болох юм шиг ойлговол гэнэн хэрэг болно.



Н.УРГАМАЛСУВД:

“КОВИД-19”-ИЙН НӨЛӨӨГӨӨР ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ХАМГИЙН БАГАДАА 1 НЭГЖ ХУВИАР СААРНА

Мөнгөний бодлогын газрын Мөнгөний бодлого, төсөөллийн хэлтсийн захирал Н.Ургамалсувдтай ярилцлаа.

Мөнгөний бодлогын хорооноос бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувь болголоо. Хэдийгээр энэ үзүүлэлт сүүлийн 2 жилд байгаагүй сул түвшин болж байгаа ч яг өнөөгийн нөхцөлд бий болоод буй эдийн засгийн хүндрэлийг даван туулахад хангалттай дэмжлэг болж өгч чадах уу?

- Бүхий л Төв банкнууд бодлогын хүүг бууруулах замаар шоконд хариу үйлдэл үзүүлж байгаа. Тэгэхээр энэ нь хангалттай юу, үгүй юу гэдгийг нөгөө талаас нь асуувал бид энэ удаагийн шокийг гүйцэд таньсан уу, үгүй юу гэж болох юм. Одоогоор “КОВИД-19” вирусийн тархалтын цар хүрээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж байна.

Түүний эсрэг авч буй улс орнуудын хариу арга хэмжээ нь 7 хоног тутамд өөрчлөгдөж байна. Тэгэхээр энэ удаагийн шийдвэрийг хангалттай, эсвэл үгүй гэж шууд дүгнэхэд хэцүү. Яагаад гэвэл бид шокоо бүрэн хэмжээгээр хангалттай таньж дуусаагүй байна гэсэн үг. Тэгэхээр ямартай ч одоогоор ороод ирчихсэн байгаа шокийн хэмжээнд хангалттай гэж хэлж болно.

Бид аль болох мөнгөний бодлогын хүүг шок хэлбэрээр бус бага хэмжээгээр, шат дараатайгаар бууруулах нь илүү үр нөлөөтэй гэж үздэг. Тийм учраас мөнгөний бодлогын хүүг нэг нэгж хувиар бууруулсан нь дотоод эрэлтийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг тэтгэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Зөвхөн өнгөрсөн долоо хоногт л гэхэд дэлхийн 30 гаруй улсын Төв банкнууд бодлогын хүүгээ бууруулж, хэт зөөлөн бодлого руу шилжиж байна. Тэгэхээр Төв банкнуудын бодлогын хүүгээ бууруулж байгаа шийдвэр нь яг ямар аюулаас сэргийлж, хамгаалж байгаа шийдвэр болох вэ?

- Ерөнхийдөө улс орнуудын нөхцөл байдал адилхан байгаа. Өөрөөр хэлбэл, Коронавирусийн тархалтын улмаас тодорхой хориг арга хэмжээнүүд тавигдсанаар үйлдвэрлэлүүд буурч байна. Үүнийг дагаад иргэдийн цалин орлого, хэрэглээ буурах эрсдэлийг үүсгэж байгаа. Тэгэхээр Төв банкнууд үүний эсрэг эрэлтийг дэмжих, хэрэглээг дэмжих, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогын арга хэмжээг авч байна гэсэн үг.

Бодлогын хүүг аажмаар, алхам алхмаар бууруулах нь зөв гэж та хэллээ. Сая хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг нэгээс дээш нэгж хувиар бууруулах боломж байсан уу? Дараагийн Мөнгөний бодлогын хорооны хурал 6 дугаар сард хуралдана. Үүнээс өмнө магадгүй ээлжит бусаар хуралдах магадлал байгаа юу?

- Мөнгөний бодлогын газраас 0.5 нэгж хувиар бодлогын хүүг бууруулах саналыг Мөнгөний бодлогын хорооны хуралд танилцуулсан. Харин хорооны гишүүдийн саналаар 1 нэгж хувиар бууруулахаар болсон.

Бид яагаад мөнгөний бодлогын хүүг 1-ээс дээш нэгж хувиар бууруулахгүй байхыг илүүд үзэж байна вэ гэхээр үүний нөгөө талд бидний валютын урсгал багассан. Энэ үед төгрөгийнхөө өгөөжийг огцом бууруулах шаардлага байхгүй гэж үзсэн.

Хоёрдугаарт, бид бодлогын хүүнээс гадна бусад арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Тэгэхээр нийлбэр нөлөөгөөрөө 1 нэгж хувиас илүү бууруулсан хэмжээнд үр дүнгээ үзүүлнэ гэж үзэж байгаа.



Бусад арга хэмжээнүүдийн хувьд хэрхэн тодорхойлж байна вэ?

- Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувь болгосон. Энэ нь банкуудын зээл олгох чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлж байгаа. Энэ нь богино хугацаанд шууд үр дүнгээ өгөх бодлогын арга хэмжээ болсон. Нөгөө талаас заавал байлгах нөөцийг бууруулсан нь зээлийн өртгийг бууруулна. Өөрөөр хэлбэл, 100 төгрөг тутмын 10.5 төгрөгийг Монголбанкинд байршуулдаг байсан бол одоо 8.5 төгрөг болсон.

Тэгэхээр энэ нь зээл гаргах төгрөгийн эх үүсвэрийн зардлыг бууруулж өгч байна. Гуравдугаарт, бид хүүний коридорыг нарийсгасан. Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулсан. Дээр нь хүүний коридорыг 1 нэгж хувиар бууруулахаар банкуудын санхүүжилт авах эх үүсвэрийн өртөг 2 нэгж хувиар буурч байгаа юм. Банкууд мөнгөн урсгалаа тооцоолсон байгаа.

Гэтэл Коронавирусийн нөхцөл байдалтай холбоотойгоор орох урсгал нь буурах эрсдэл өндөр байгаа. Гарах урсгал нь өндөр хэвээр байгаа үед орох урсгал нь багассанаар банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Тийм учраас Монголбанк банкуудад олгох эх үүсвэрийнхээ хүүг бууруулж, банкуудад хямд эх үүсвэр татах боломжийг нь нээж өгч байгаа юм.

Зээлийн эх үүсвэрийн өртгийг хямдруулах эрэлт хэрэгцээ их байх шиг байна. Тэгэхээр энэ арга хэмжээ валют талдаа ямар нөлөө үзүүлэх бол?

- Төгрөгийн ханш сулраад эхлэхээр пассивын долларжилт буюу доллараар хадгаламж хийх байдал нэмэгддэг. Энэ хандлага сүүлийн улирлуудад нэлээд ажиглагдаж байгаа. Тэгэхээр бид төгрөгийн заавал байлгах нөөцийг бууруулаад, долларын заавал байлгах нөөцийг бууруулаагүй шалтгаан нь энэ юм.

Өөрөөр хэлбэл, бид долларжилтыг аль болох бууруулж, аль болох төгрөгөөр эх үүсвэр татах сэдлийг үүсгэхийг зорьж байгаа юм. Хадгаламжийн хувьд ийм байгаа бол зээлийн хувьд ханш суларч байгаа үед угаасаа л буурах хандлагатай байдаг. Энэ утгаараа зээлийн долларжилт буурч байгаа.

Инфляцын хувьд Монголбанкны зорилтот түвшнээс бага байгаа. Үүнд юу нөлөөлж байна вэ. Цаашдын төлөв нь ямар байна вэ?

- Эрэлтийн шалтгаантай инфляц өнгөрсөн жилүүдэд харьцангуй алгуур нэмэгдэх трэндтэй байсан. Харин нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нь нийт Инфляцын хэлбэлзлийн дийлэнхийг тайлбарлаж байсан. Бид тухайн үед нь тайлбарлаж байсан. Махны үнэ, хатуу түлшний үнэ, шатахууны үнийн өсөлтүүд Инфляцын хэлбэлзэлд хүчтэй нөлөө үзүүлж байсан.

Энэ нөлөөлөл сүүлийн үед буураад байгаа. Ялангуяа шатахууны үнэ дэлхийн зах зээл дээр буурчихлаа. Дээрээс нь хатуу түлшний үнэ сайжруулсан түлшний хэрэглээтэй холбоотойгоор тогтворжиж байна.

Харин махны үнийн нөлөө хэвээр хадгалагдаж байна. Махны үнийн хувьд өнгөрсөн 5, 6 дугаар сард гол өсөлт нь гарсан. Тэгэхээр суурь үеийн нөлөө арилах арай болоогүй байна. Дээрээс нь нэгдүгээр сарын сүүлийн 7 хоногт нэлээд өссөн.

Хоёрдугаар сарын эцсийн байдлаар инфляц улсын хэмжээнд 6.4, Улаанбаатар хотын хэмжээнд 6.9 хувьтай болж өссөн байгаа. Үүний дийлэнх буюу 2.3 нэгж хувийг махны үнийн өсөлт тайлбарлаж байгаа. Эрэлтийн шалтгаантай Инфляцын хувьд шинэ Коронавирусийн нөлөөллөөр буурна гэж харж байгаа. Тийм учраас бид нийт Инфляцын төсөөллийг бага зэрэг бууруулсан.

Нийлүүлэлтийн шалтгаантай инфляц тодорхой хэмжээнд үүсэх эрсдэл бий. Гэхдээ хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нөөцийг харвал Монгол Улс энэ жил боломжийн хэмжээнд махны нөөцөө бүрдүүлсэн гэж байгаа. Тэгэхээр махны хувьд гайгүй байх болов уу гэсэн хүлээлттэй байгаа.

Импортын зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хувьд хилийн хориг удаан хугацаанд тавигдахтай холбоотойгоор нийлүүлэлтийн хэлбэлзэл үүсэх эрсдэл бий. Гэхдээ гурилын нөөц одоогоор хангалттай, мөн нэмэлт нөөц бүрдүүлж байна.

Ерөнхийдөө гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хувьд харьцангуй гайгүй байгаа. Гол эрсдэл юу байна вэ гэхээр махны экспортын хувьд 3 дугаар сарын 30-ныг дуустал хориг арга хэмжээ тавьсан. Гуравдугаар сарын 30-наас хойш хориг арга хэмжээг цуцалсан тохиолдолд Хятадын талаас мах импортлох эрэлт нэлээд өндөр байгаа.

Өөрөөр хэлбэл, өнгөрсөн хоёр жилд гахайн ханиад гарсан. Дээрээс нь шувууны ханиад гарчихлаа. Мөн "КОВИД-19"-ын тархалттай

холбоотойгоор далайн гаралтай бүтээгдэхүүний эрэлт нэлээд буурч байна. Тэгэхээр бусад мах буюу хонь, үхрийн махны эрэлт нэмэгдэж байгаа. Тиймээс бидний хувьд үүнтэй холбоотойгоор нойтон махны нийлүүлэлт нэмэгдэх хүртэл махны экспортын хоригийг үргэлжлүүлэх хэрэгтэй гэж үзэж байгаа.

Төв банкны хувьд өндөржүүлсэн бэлэн байдал зургаадугаар сар хүртэл үргэлжилбэл, эдийн засгийн өсөлтийн хэмжээ 2.0 хувь хүртэл буурна гэж байсан. Үүнээс хойш эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд ямар нэгэн өөрчлөлт орсон уу?

- Би ярилцлагын эхэнд хэлсэнчлэн бид шокоо бүрэн хэмжээнд таниагүй байгаа. Тэгэхээр төсөөллийг шинэчлэхийн тулд шокоо бүрэн хэмжээгээр, тоо хэмжээгээр илэрхийлэх шаардлагатай болно.

Глобал орчноос үүдэлтэйгээр "КОВИД-19"-ийн эдийн засгийн нөлөө Монгол улсад аль аль сувгаар илүү орж ирэх магадлалтай байна вэ?

- Том дүр зургаар нь харвал бид ойрын хугацаанд шокоо таньж чадахгүй. Тэгэхээр бид хувилбар төсөөллүүдээ хийж байгаа. Одоогийн мэдээллүүдэд суурилоод, хамгийн багадаа ямар нөлөө үзүүлэх вэ. Хамгийн ихдээ ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг харахаар таны хэлсэнчлэн эдийн засгийн өсөлт хамгийн муугаар бодоход 2.3-2.5 хувь хүртэл буурахаар байгаа. Хамгийн сайнаар төсөөлөхөд эдийн засгийн өсөлт бидний өмнө нь төсөөлж байснаас 1 нэгж хувиар буурч, 4.1-4.2 орчимд хүрэхээр төсөөлсөн. Бодит амьдрал хамгийн муу болон хамгийн сайн төсөөллүүдийн дундуур, хаа нэг хэсэгт л тусах болов уу.

Ярилцсанд баярлалаа.

ГУРАВДУГААР САРЫН БАЙДЛААР 5.3 ТОНН ҮНЭТ МЕТАЛЛ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2020 оны 3 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр нийт 5.3 тн үнэт металл худалдан авсан бөгөөд үүнээс 2020 оны 3 дугаар сард 830 кг үнэт металл худалдан авсан. Энэ нь өмнөх оны мөн үед 540 кг үнэт металл худалдан авч байснаас 290 кг-аар өссөн үзүүлэлттэй байна. Нийт 5.3 тн үнэт металаас 3.6 тн алт, 1.7 тн цагаан мөнгө байна.

2020 оны 3 дугаар сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 31 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 36 кг үнэт металл тус тус худалдан авсан байна. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж үнэ 2020 оны 3 дугаар сард 141,512.11 төгрөг байлаа.


Дүрслэл 1. 2018-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын сарын мэдээ (кг)



Дүрслэл 2. 2020 оны 3 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)




Дүрслэл 3. 1990-2020 онд Монголбанкны худалдан авсан үнэт металлын хэмжээ (тонн)



ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

Банк Хоорондын Валют Арилжааны Цахим Талбар (БХВАЦТ)-ыг 2017/4/10-нд нэвтрүүлсэнээс хойш 2020/03/31-ний хооронд 2,069.5 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1439 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ЗАМ

(СУРГАМЖ, СОРИЛТ, БОЛОМЖ)

ОНБМТ-ийн ахлах мэргэжилтэн Д.Ариунаа
НОМЫН ТЭМДЭГЛЭЛ

Ийм нэртэй нэгэн номонд Монголчуудын хөгжлийн замыг зураглажээ. Монголбанкны Ерөнхий эдийн засагч, эдийн засгийн ухааны доктор Д.Ган-Очирын манай улсын макро эдийн засгийн эрүүл мэндэд онош тавьж, тогтвортой өсөлт, хөгжлийн тохирох жорыг эрэлхийлсэн бүтээлүүд энэ ном болтлоо 15 жилийг ардаа охижээ. Өнөөдөр бид 36.8 их наяд төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл туулсан санхүү, эдийн засгийн харилцаа нь эртний монголоос улбаатай бөгөөд бидний байгуулж ирсэн нийгмүүдэд эдийн засгийн амьдрал ямар өнгө төрхтэй байсан тухай түүхэн өгүүллүүдээс уг номны агуулга эхэлнэ.

Ардын хувьсгалын дараа Үндэсний банк байгуулагдсанаар Монголд орчин цагийн санхүүгийн тогтолцооны суурь тавигдсан гэж үздэг ч, түүнээс өмнөх түүх III зуун буюу Хүннү гүрний үед зоос, мөнгө хэрэглэж эхэлснээс эзэнт гүрний байлдан дагуулалт, худалдаа арилжаа хийж байсан үеүд нь Монголчууд бид мөнгө, санхүүгийн баялаг их түүхтэй болохыг гэрчилдэг. Ийнхүү түүхэн үечлэл бүхий хөгжлийн урт удаан замыг туулахдаа өнгөрсөнөөс сургамж авч, цаашид эдийн засгийн бодлогын түвшинд анхаарах асуудлуудыг дэвшүүлсэн тус номноос бид эдийн засгийн бие даасан шийдвэр гаргах чадавхитай болж бэхжих хэрэгтэйг ойлгоно.

Монгол Улсын эдийн засаг улс төрийн циклтэй. Иймд бодлогын тогтвортой байдал алдагдах



эрсдэлийг байнга дагуулж байгаа тул бид эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийх шаардлага байгааг судлаач хэлжээ. Авч үлдэх сургамжийг маш тодорхой тоочсон байна:

- Улс төрийн болон эдийн засгийн хүртээмжтэй институци бүрдүүлэх
- Гадаад шоконд эмзэг байдал, түүний үр дагаварыг бууруулах
- Эдийн засгийн өрнөлийн үед нөөц хөрөнгө хуримтлуулах
- Хөрөнгийн урсгалыг төсөв, мөнгөний бодлогоор бүрэн удирдахад туйлын хүнд тул макро зохистой бодлогын арга хэрэгслийг ашиглах
- Богино хугацааны хэрэглээнээс илүүтэй урт хугацааны хөгжилд чиглэсэн бодит ажил хийх
- Төсвийн сахилга батыг чанд мөрдөх
- Гадаад, дотоод өрийн удирдлагыг сайжруулж, үр ашигтай хөрөнгө оруулалт дагадаг болгох
- Төв банкны мөнгөний бодлого, үйл ажиллагааг үндсэн зорилтоо хангахад эн тэргүүнд чиглүүлэх



- Зах зээл дэх төрийн 'хэт' оролцоог хязгаарлах, засаглалыг сайжруулах
- Төгрөгийн гадаад валюттай харилцах ханшийг 'хүчээр' хамгаалахгүй байх
- Урсгал тэнцэл нь эдийн засгийн барометр тул ашигтай болгоход бүх талаар анхаарах
- Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх – үндэсний банкны тогтолцоо нь хүчирхэгжиж, тогтвортой бус тохиолдолд эдийн засгийн тогтвортой байдал бүрдэхгүй
- Өр, зээлийн харилцааны зохистой байдлыг хангах

Манай улс зах зээлийн нийгэмд шилжсэнээс хойших өнөөдрийг хүртэлх хугацаанд эдийн засгийн хүндрэлтэй цөөнгүй тулж, зургаан ч удаа ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлж иржээ. Гэвч эдийн засгийн эмзэг байдал, богино давтамжтай эдийн засгийн хүндрэл, хямралд ордог байдал хэвээр байсаар байна. Гэтэл хүндрэл бэрхшээлд хүргэж буй нийтлэг шалтгаан нь ижил буюу дээрх үндсэн хүчин зүйлс болохыг тодорхой баримт, нотолгоонд тулгуурлан тайлбарлажээ. Тэгвэл эндээс бидэнд засаж залруулах алдаа нь тодорхой харагдаж байгаа тул алдаанаас залруулага руу, хоцрогдлоос хөгжил рүү хүрэх ямар боломж

байгаа тухай бодит байдалд суурилсан шинжлэх ухааны үндэслэлтэй дүн шинжилгээнүүд хийжээ. Энэ тухайд цаашид баримтлах бодлогын "жанжин шугам"-ыг гаргажээ. Үүнд үндсэн цөөг тооны зарчмыг онцолсон байна.

Нэгдүгээрт: Засаглал, институцийг бэхжүүлэхгүйгээр хөгжлийн боломжуудаа алдсан хэвээр байх тул энэ хэсэгт эмх цэгц бүхий эрх зүйн 'хатуу' зохицуулалт нэгэнт үгүйлэгдэж буй.

Хоёрдугаарт: Бидний хувьд байгалийн баялгийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлж, хөгжих боломж байгаа тул баялгийн орлогоо бүрэн хянах, эрх зүйн болон татварын зохицуулалтыг хийх, хуримтлал үүсгэж, урт хугацааны хөгжлийн дэд бүтэц болон эдийн засгаа төрөлжүүлэхэд зарцуулах эс бөгөөс цаашдын хөгжлийн тухай бодоход хүнд болохыг хэлжээ.

Гуравдугаарт: Эдийн засгаа төрөлжүүлэх, урт хугацааны хөгжлийн реформ хийх тухай юм. Энэ сэдэв бол эдийн засагч бүрийн санаа тавьдаг асуудал. Гагцхүү шийдэл нь юу вэ гэдэг нь гол асуудал юм. Харин эдийн засагч Д.Ган-Очир эдийн засгийн төрөлжилтийг бий болгохын тулд нөөцийн салбартай уялдаатай бусад салбаруудыг дэмжих шаардлагатай гэдгийг задлан тайлбарласан бөгөөд гадаадын хөрөнгө

оруулалт, худалдаа, эдийн засгийн бүтцийн төрөлжилтийг харилцан уялдаатай, тууштай хийж хэрэгжүүлснээс хойш 15 жилийн дараа эхний үр дүнгүүд тоон дээр харагдаж эхэлдэг тухай дурдаж, Монгол Улсын хөгжил энэ хэрээр хоцорч байна хэмээжээ.

Дөрөвдүгээрт: Ядуурал болон тэгш бус байдлыг бууруулах, эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг бий болгох шаардлагыг онцгойлон хөнджээ. Энэ тухай хэлсэн гол санаа нь төр харьцангуй өндөр орлоготой хэсгээс татвар авч орлого багатай зорилтот бүлэгт зайлшгүй шаардлагатай байгаа дэмжлэгийг үзүүлэх ёстой бөгөөд өсөн нэмэгдэх татварын тогтолцоонд шилжих, нийгмийн тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт шилжүүлэх зэрэг нь энэ зорилтод хүрэх эхний зайлшгүй нөхцөл гэж үзжээ.

Тавдугаарт: Төв банкны хараат бус байдлыг сахин хамгаалах хэрэгтэй бөгөөд одоо байгаа хууль, эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангахад онцгой анхаарах шаардлагатай. Хэрэв Монголбанк 2012-2016 онд хэрэгжүүлсэнтэй адил төсвийн шинж чанартай үйл ажиллагааг дахин давтах тохиолдолд Монголын эдийн засгийн дархлаа ноцтой суларч, эдийн засгийн аюулгүй байдалд 'том' хохирол учруулахыг сануулжээ.

Зургаадугаарт: Банкны салбарын тогтвортой байдалд онцгой анхаарах хэрэгтэй. Үүний тулд банкуудын мөчлөг дагасан үйл ажиллагааг бууруулсан, банкны системийн тогтвортой байдлыг хангах чиглэлд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, шаардлагатай тохиолдолд албадлагын арга хэмжээ авах, банкны системийг сайжруулах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх нь чухал болохыг тодорхой өгүүлжээ.

Долоодугаарт: Гадаад өрийн түвшин өндөрт хүрсэн өнөөгийн нөхцөлд санхүүгийн сахилга бат туйлын чухал болохыг онцолжээ. Ингэхдээ үндсэн секторуудын мэдээлэлд суурилсан Балансын аргачлалаар Монголын эдийн засгийг шинжлээд

цаашид эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг нэгэн зэрэг хангахад гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй санхүүжилт зайлшгүй шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Наймдугаарт: Логистикийн салбарыг хөгжүүлэх нь өртөгийг бууруулах гол суурь болох тухай санаа юм. Манай улсад хүнс барааны үнэ өндөр хэлбэлзэлтэй. Гол хүнсний нэрийн бүтээгдэхүүнүүд нь улирлын шинж чанартайгаас хамаарч үнийн хэлбэлзлийг үүсгэх гол шалтгаан болдог. Дээр нь импортын бараа бүтээгдэхүүний өртөгийн 25 хувь нь логистиктой холбоотой байдаг нь ч бас нөлөөлнө. Үүнээс үүдэлтэй өндөр инфляц бодлогын хүүг өсгөж, эдийн засагт хүүний ерөнхий түвшин буурахгүй байна. Иймд худалдан борлуулалтын үечилсэн олон шат дамжлагыг бууруулах, нөөц бүрдүүлдэг байх гэх мэт локистикийн үр ашигтай тогтолцоог сайжруулснаар инфляц тогтвортой байх, улмаар хүү буурах, эдийн засагт бодит сектор сэргэх боломжтой тухай тодотгожээ.

Ийнхүү Монгол Улсын эдийн засагт шийдлээ хүлээж буй олон сорилт, асуудлууд байгааг судлахдаа олон улсын сайн, муу туршлагуудтай харьцуулах замаар олон чухал асуудлыг хөнджээ. Тухайлбал, улсын өрийн дефолтын эдийн засаг, улс төрийн зардал ямар байдгийг, түүний сөрөг нөлөө, хэрхэн өрийн удирдлагыг боловсронгуй болгох, байгаа боломжуудаа ашиглаж хэрхэн тогтвортой өсөлтөд хүрэх, үүний тулд төсвийн бодлого дахь улс төрийн нөлөөг хязгаарлах, банкны хямралын зардлыг бууруулах, макро бодлогын хэрэгслүүдийг хэрхэн оновчтой ашиглах зэрэг бодлогын гаргалгаануудыг нарийвчлан гаргажээ. Үүгээрээ "Монголын хөгжлийн зам ном" нь дан ганц макро эдийн засгийн хүрээнд хязгаарлагдаагүй, Монгол Улсын эдийн засгийг бүхлээр нь авч үзсэн тул бид ер нь хаашаа явж байна вэ гэдгийг сонирхсон хэн бүхэнд бэлээхэн дэлгээтэй томоохон судалгаа бүхий судлагдахуун бүтээл болжээ.



“КОВИД-19”-ийн НӨЛӨӨ БАНКНЫ САЛБАРТ ОЛОН СУВГААР МЭДРЭГДЭЖ БАЙНА.

Монголын Банкны Холбооны
Гүйцэтгэх захирал Л.Амартай ярилцлаа.



Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуульд 1997 онд элсэн орж, 2001 онд эдийн засагч, менежер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгсч, 2001–2003 онд Монголбанкны Тамгын газарт гадаад харилцааны мэргэжилтэн, 2003–2005 онд Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газарт Дэлхийн Банкны санхүүжилттай “Төлбөрийн системийг шинэчлэх дэд төсөл”-д төслийн зохицуулагчаар ажилласан. Тэрээр 2005–2006 онд Люксембургийн Санхүүгийн Сургууль, Нью-Йоркийн Их Сургуулийн хамтарсан хөтөлбөрт суралцаж, банк санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэгтэй төгссөн. 2006-2010 он хүртэл Монголбанкинд Хяналт шалгалтын газарт Хянан шалгагчаар 2010 он хүртэл ажилласан.

Л.Амар нь Азийн Хөгжлийн Банкны (ADB) Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газарт 2011–2019 онд эдийн засагчаар ажилласан бөгөөд 2020 оны нэгдүгээр сараас Монголын Банкны холбооны гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Таны хувьд урд нь Төв банканд ажиллаж байсан туршлагатай ч одоо бол нийт арилжааны банкны эрх ашгийн төлөө ажиллах боллоо шүү дээ. Ажлаа аваад бүтэн улирал болоогүй байгаа ч танд төрж буй эхний сэтгэгдлийг тань сонсохыг хүсч байна.

- Өмнө нь анзаардаггүй байсан өөр өнцгөөс одоо энэ салбараа харж байна. Монголбанканд байхдаа банкуудад зайнаас хяналт тавиад, материалыг нь хүлээн авч шалгаад, хааяа газар дээрх хяналт шалгалт хийх зэргээр л ажиллаж байсан. Харин одоо банкуудын өдөр тутмын үйл ажиллагаа, бэрхшээл юу байдаг, Монголбанкнаас

гарч байгаа тушаал, шийдвэрүүд амьдрал дээр хэрэгжихэд ямар асуудал тулгардаг вэ гэх зэргийг өдөр бүр харж, суралцаж байна. Миний хувьд ажлаа хүлээн авахтай зэрэгцэн Корона вирусын өндөржүүлсэн бэлэн байдал зарлагдаж, зээлийн төлөлт, хүү хойшлуулах асуудал сөхөгдөж эхэлсэн. Улиралд нэг хуралддаг МБХ-ны Удирдах зөвлөл долоо хоног бүр, зарим үед хоёр удаа хуралдаж, бизнесүүдэд учрах эрсдлийг хэлэлцсэн. Тэгэхээр зовлонг нь илүү ойлгодог юм байна. Төв банк банкны салбарын эрүүл мэнд талаас нь анхаарч, онолын шийдвэрүүд гаргадаг. Гэтэл онолын шийдвэрүүд хөрсөнд буугаад амьдралд хэрэгжих

хүртэлх процесс, хүндрэл талаас нь хардаггүй байж. Монголбанкны хянан шалгагчийн нэг шийдвэр банкны салбарт ажилладаг 16,000 хүний амьдралыг зохицуулж байгаа шүү дээ.

Хүндхэн сорилттой тулгарсан хүнд үед та банкны салбарт дахин орж ирлээ. Банкны салбар эдийн засгийг хөдөлгөгч чухал хөдөлгүүр. Үүндээ ч юм уу нийгэм их зүйл хүсч байна. Энэ бүхэнд нийцүүлж ажиллах хүч тэнхээ манай банкныханд хэр байна вэ?

- Миний хувьд дөнгөж их сургуулиа төгсөөд, ажилд орох үед хүн бүхэн л банканд орж ажиллах юмсан, банкны салбар “гоё” гэсэн ойлголттой байсан. Тэр үед буюу 2000-д онд зээлийн хүү сарын 4 хувь гаруй байсан. Зээлийн хүртээмж гэдэг зүйл үндсэндээ байхгүй. Банкнаас зээл авна гэдэг нь нийт иргэдэд бараг хүртээлгүй, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид л зээл авдаг. Иргэдэд зориулсан хэрэглээний зээл, кредит, дебит карт гэх зүйл байхгүй. Иргэд үндсэндээ мөнгөө хадгалуулах гэж л банкинд очдог, банкууд байгууллагын зах зээл дээр илүүтэй ажилладаг байсан. Нэг ёсондоо банк нийт иргэдэд бараг хамаагүй, цөөн хэдэн аж ахуйн нэгжүүдийн л асуудал байсан.

Одоо 20 жилийн дараа энэ салбарыг эргээд харахад иргэддээ хүрч үйлчлэх талаараа асар хурдацтай хөгжсөн, салбар нэгжийн хүртээмж, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ, төлбөр тооцооны түргэн шуурхай, найдвартай байдалд үлэмж дэвшил гарснаас гадна иргэдийн хувьд гар утаснаасаа гүйлгээ хийчихдэг, зээлээ хүртэл онлайнгаар авдаг болсон цаг шүү дээ. Үйлчилгээ иргэдэд ойртсон байна. Үүний зэрэгцээ зээлийн хүүг сараар биш, харин жилээр ярьдаг болж, хүүгийн түвшин буурсан.

ИЙМ ТҮВШИНД ХҮРЧИХСЭН БАЙХАД Л БАНК РУУ ДАЙРСААР БАЙНА ГЭДЭГ НЬ НАДАД БОЛЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙГААР НЭГ ХЭСЭГ ХҮМҮҮС БҮХ СӨРӨГ ЭНЕРГИЙГ ЧИГЛҮҮЛЭЭД БАЙНА УУ, ЭСВЭЛ ЗҮГЭЭР Л “АЛТАН ЗАГАСНЫ ҮЛГЭР” ГЭДЭГ ШИГ ИЛҮҮ ИХИЙГ ХҮСЭЭД БАЙГАА Ч ЮМ ШИГ ХАРАГДААД БАЙГАА ЮМ.

Сумын төв рүү мотоциклтой хоёр гурван цаг давхиж байж, хүүхдийнхээ сургалтын төлбөрийг сургуульд нь шилжүүлдэг байсан цаг саяхан. Банкнаас зээл авах бус ах дүү, хамаатан саднаасаа гуйгаад л явдаг байсан шүү дээ.

Тэгэхээр яг ямар суурин дээрээс банк руу дайраад байна вэ гэдгийг би хувьдаа ойлгохгүй байгаа юм. Нэгэнт банкинд хүү төлөх дургүй байгаа бол эргээд найз нөхөд, хамаатан саднаасаа л мөнгө гуйдаг, тэр зүйл рүүгээ явмаар юм шиг.

Гэхдээ л иргэд банкны салбараас илүү зүйлийг хүсээд байна...

- Байр, машин аваад хэрэглэх боломжийг нь хангаж өгч байгаа нь уг нь банкны буруу биш л дээ. Би банкуудыг хаацайлаад байгаа юм биш. Гэхдээ иргэдэд банкнаас үзүүлж байгаа үйлчилгээ миний анх ажилд орж байх үеийнхээс тэнгэр газар шиг зөрүүтэй болсон. Аж ахуйн нэгжүүдийн хувьд ч мөн ялгаагүй.

Том том компаниудтай ажилладаг банк бол сая сая долларын зээлийн шугамыг олон жилийн харилцаатай, найдвартай харилцагчиддаа бараг барьцаагүй шахам нээгээд өгчихсөн л байдаг юм билээ. Тийм их хэмжээний санхүүгийн чөлөөтэй эх үүсвэр өмнө нь байдаггүй байсан.

Өндөр хөгжилтэй, хөгжингүй орнуудад хүртэл төлбөр тооцоо гүйцэтгэх, банкаар үйлчлүүлэхэд ямар их чирэгдэлтэй, кредит карт нээлгэхэд хүртэл ямар их хүндрэл учирдгийг бодох л хэрэгтэй. Хөгжингүй гэх Америкт банкны гүйлгээний шимтгэл, ПОС машины шимтгэл өндөр хэвээр байна. ПОС-ын гүйлгээ нь 3 хувийн шимтгэлтэй, банк хоорондын гүйлгээ нь ажлын 7 хоногтоо орж байвал хурдан гэж үздэг улс орон олон.

Монголбанк үндэсний цахим гүйлгээний төвөөрөө дамжуулаад, банк дундын систем, төлбөр тооцоог олон улсын түвшинд дээгүүр жагсах хэмжээнд хүргэж чадсан. Үүнийг нь банкууд иргэдэд хүртээмжтэй, санхүүгийн бүтээгдэхүүн болгож, шуурхай, чирэгдэлгүй ажиллах гэж өдөр тутам хичээж л байна. Тийм байхад “Хорвоогийн дайсан: банк” гэж хандах нь арай л өрөөсгөл юм даа.

Тэгвэл банкны салбарт COVID-19 вирусийн нөлөө хэрхэн тусч байна вэ?

- Шууд болон дам хэд хэдэн сувгаар мэдрэгдэж байна. Нэгдүгээрт, бодит санхүүгийн дарамт одоо үйл ажиллагаа нь хүндэрч байгаа аж ахуйн нэгж, иргэдээс ирнэ. Зээл төлөгдөхгүй байна гэдэг маань шууд актив талдаа хүндрэл үүсгэнэ.

Өөрөөр хэлбэл зээлийн эргэн төлөлт нь пассив буюу эх үүсвэртэйгээ уялдаатай. Гэтэл актив талдаа аж ахуйн нэгжүүд хүндрээд, зээл төлөгдөхгүй болоод эхлэхээр пассив талдаа дутагдлууд үүсээд эхэлж байна. Нэг сар гаруйн хугацаанд нүүрсний экспорт зогслоо. Үүнийг дагаад энэ салбарт үйлчилгээ үзүүлдэг бензин шатахуун, сэлбэг хэрэгсэл гэх зэрэг дагалдах бизнесүүд нь таг зогсож байгаа юм.

Үйлчилгээ, худалдааны салбарт ч дийлэнх хэсэг нь зогсонги байдалд орсон. Хэдийгээр хөл хорио тогтоосны эерэг нөлөө боловч эмнэлгүүд хоосорч, хүмүүс эм авах нь багасч байна гэх зэргээр эдийн засгийн эргэлттэй явж байсан зүйл сулраад эхлэхээр бүх аж ахуйн нэгжүүддээ нөлөөлөөд, тэр нь эргээд банкууддаа нөлөөлөх эрсдэлтэй болж байна.

Хоёрдугаарт, цалин, орлоготой байсан хүмүүс цалингүй, орлогогүй болоод, гэртээ суугаад эхлэхээр хадгаламжаасаа авч хэрэглэж эхэлж байна. Тэгэхээр актив талдаа буурч байсан бол пассив талдаа бас нөлөөлөл үүсч эхэлсэн. Гуравдугаарт, төр засгийн гэнэтийн шийдвэр зарим талаар сөрөг үр дагавар дагуулж байна.

БАНКНЫ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА 55 ХУУЛЬ, 69 ЖУРМААР ЗОХИЦУУЛАГДДАГ. COVID-19-ИЙН ХҮРЭЭНД ҮҮНЭЭС 2 ЖУРАМД Л ӨӨРЧЛӨЛТ ОРСОН, БУСАД ХУУЛЬ ЖУРМААР ТОГТООСОН ХЯЗГААРЛАЛТУУД ХЭВЭЭР МӨРДӨГДӨЖ БАЙГАА. УЛС ТӨРИЙН ШИЙДВЭРИЙГ ОЛОН НИЙТЭД ЯАРАН ЗАРЛАСАН НЬ БАНКУУДАД ОЛОН АСУУДАЛ ҮҮСГЭСЭН.

Шийдвэрийг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй цаг үед иргэд банкны салбарыг буруутгах нь нэмэгдсэн. Учир шалтгааныг нь тайлбарлах, иргэдэд ойлгуулах шаардлага үүссэн.

Ийм үед банкны холбооноос олон нийтэд чиглэсэн бодлогын ямар ажил хийх нь зүйтэй гэж харж байна вэ?

- Банкууд, Монголбанк, Банкны холбоо энэ чиглэлд ажиллах шаардлагатай гэдгийг ойлгоод, тал талдаа ажиллаад л явж байгаа. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэхгүй бол хүмүүс үнэндээ инфляц гэж юу вэ, зээлийн хүү гэж юу вэ гэдгийг мэдэхгүй, ойлгохгүй байна.

Америк, Японд зээлийн хүү 3 байхад Монголд яагаад 0 байж болдоггүй юм гэх байдлаар хандаж байгаа. Яг улс орныхоо нөхцөл байдлыг хараад, инфляц яагаад үүсдэг юм, зээлийн хүү юун дээр тогтдог вэ, валютын ханшийн эрсдэл нь юу байна вэ, яагаад долларын ханш чангараад, сулраад байна вэ гэдгийг хүмүүст сайн ойлгуулах хэрэгтэй. Ядаж анхны ойлголтыг нь өгөхгүй бол бид яаж ч яриад ойлгохгүй юм билээ. Тэгэхээр иргэдийн санхүүгийн боловсролын наад захын ойлголтыг сайжруулах хэрэгтэй байна. Хамгийн энгийнээр хүмүүст хүргэх, хувь хүн өөрийнхөө санхүүг аваад явчих ойлголттой байх хэрэгтэй. Сургуулийн хөтөлбөрт ч энэ талаар тусгах нь зүйтэй.

Банкны салбарт реформ хийх асуудлыг төр засгаас тавьж байна. Харин банкны салбар энэ асуудлыг хэрхэн харж байна вэ?

- Банкууд харилцан адилгүй, өөр өөр бодолтой байгаа байх. Үүнийг би төлөөлөөд хариулна гэдэг хүндрэлтэй. Реформ гэдэг утгаараа засаглал, үйл ажиллагаа, санхүүжилт, үйлчилгээ гээд бүх түвшинд нь олон улсын жишиг рүү хүргэхийг зорьж байгаа байх.

Ингэхдээ ОУВС-тайгаа хамтраад, олон улсын стандарт, норм шаардлагад хүргэх зорилготой байгаа болов уу гэж бодож байна. Монголбанк зөв тал руу нь чиглүүлээд явбал, дэмжээд л ажиллахаас өөр аргагүй.

Ярилцсанд баярлалаа.

№2

ТӨГРӨГ



ЖИН: 20 ГР, ГОЛЧ: 33ММ, МЕТАЛ: МӨНГӨ 900

НҮҮР ТАЛ: БАДАМ ЦЭЦГЭН СУУРИН ДЭЭР "НЭГ ТӨГРӨГ", ХҮРЭЭН ДОТОР ХАГАС ДУГУЙРУУЛАН "БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛС" ГЭЖ МОНГОЛ БИЧГЭЭР БИЧСЭН. АР ТАЛ: СОЁМБО СҮЛДИЙГ ДҮРСЛЭН, ЗҮҮН ТАЛД НЬ "ЦЭВЭР МӨНГӨ НЬ", БАРУУН ТАЛД НЬ "АРВАН НЭГЭН ГРАММ" ГЭЖ МОНГОЛ БИЧГЭЭР, ДООД ТАЛД ОНЫГ ЗУРХАЙН ТООГООР ТУС ТУС БИЧСЭН.

УЛС ОРНУУДЫН МӨНГӨНИЙ БОДЛОГОД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

COVID-19 вирусийн өвчлөл, түүний дэгдэлттэй тэмцэх, нийгэм-эдийн засгийн хохирлыг хязгаарлахын тулд дэлхийн улс орон тус бүр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. ОУВС-ийн зүгээс тэдгээр мэдээллийг нэгтгэж, 3-р сарын сүүлийн байдлаар дэлхийн 186 орноос авч хэрэгжүүлээд байгаа бодлогын арга хэмжээнүүдийг мэдээллээ. Иймд энэ удаагийн дугаараар зарим улсуудын авч хэрэгжүүлээд байгаа мөнгөний бодлогын шийдвэр, арга хэрэгслүүдийг онцолж, тоймлон хүргэж байна.



АНУ | Холбооны нөөцийн банк хүүгээ нийт 150 суурь нэгжээр бууруулж, 0-0.25% хооронд тогтоогоод байна. Засгийн газрын болон бусад этгээдүүдээс худалдаж авах үнэт цаасны хэмжээгээ нэмэгдүүлж, овернайт ба хугацаат репо санхүүжилтүүдийг нэмэгдүүллээ. Холбооны нөөцийн банк, бусад нөлөө бүхий Төв банкнуудын своп шугамын зардлыг бууруулж, хугацааг сунгаснаар, своп хэлцлийг өргөжүүлэн ашиглаж эхлэв.

Мөн АНУ-ын Сангийн яамны зүгээс Валютын ханшийн тогтвортой байдлын санг ашиглаж санхүүжүүлэх замаар Холбооны нөөцийн банк зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэллээ. Ингэхдээ (i) компаниуд болон бүс нутгийн засаг захиргаанаас гаргасан барьцаагүй облигац, өрийн бичгийг санхүүжүүлэх (ii) хөрөнгө оруулалтын агентлагаас үнэлсэн барьцаат үнэт цаасыг анхдагч дилерүүдээр дамжуулж санхүүжүүлэх (iii) мөнгөний анхдагч зах дээрээс өндөр үнэлгээ бүхий активыг худалдаж авч банкуудад санхүүжилт олгох (iv) компаниудын шинэ бонд, зээлийг анхдагч захаас худалдаж авах (v) компаниудын урд нь гаргасан бонд, зээлийг хоёрдогч захаас авч

хөрвөх чадварыг нь нэмэгдүүлэх (vi) оюутны зээл, машины лизинг, кредит карт, бага дүнтэй бизнесийн зээлийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаар дамжуулж санхүүжүүлэх гэх мэт арга хэмжээнүүдийг авч байна. Мөн Fannie Mae / Freddie Mac зэрэг банкуудын зохицуулалтуудыг зөөлрүүлэв.

Европын Төв банк | Мөнгөний бодлогыг дэмжих дараах арга хэмжээг аваад байна. (i) Актив худалдан авалтаа үргэлжлүүлж 120 тэрбум еврогийн активыг 2020 оны эцэс гэхэд төвлөрүүлэх (ii) өмнө олгогдсон зээлийг дахин санхүүжүүлэх зорилготой санхүүжилтийн шугамыг хадгаламжийн хүүтэй, хөнгөлөлттэй нөхцөлтэйгөөр 2020 оны 6 сараас 2021 оны 6 сар хүртэл нээж, хувийн болон нийтийн секторын активыг худалдаж авах 750 тэрбум еврогийн хөтөлбөрийг 2020 оны эцэс хүртэл хэрэгжүүлж, евро системийн дахин санхүүжүүлэх ажиллагаанд барьцаа хөрөнгийн стандартыг хөнгөрүүлэх арга хэмжээнүүдийг авав.

Эдгээр арга хэмжээнүүд нь Евро бүсийн орнуудад хамааралтайгаас гадна улс орон тус бүр өөрийн нэмэлт арга хэрэгслүүдийг ашиглаж байна.

Япон | Японы Төв банк овернайт болон хугацаат репо санхүүжилтийг хөрвөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд өргөжүүлсэн. Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаа тогтвортой явах, зээл олголтыг урамшуулах арга хэмжээнүүдийг авахаар болов. Энэ нь Японы засгийн газрын үнэт цаасыг худалдаж авах замаар зорилтот бүлэгт санхүүжилтийг олгохыг дэмжиж, Төв банк засгийн газрын сангуудад хөрөнгө оруулах замаар корпорациудад зээл олгох тусгай зориулалтын санхүүжилтийг бий болгоход чиглэнэ. 3-р сарын 24-ний байдлаар Японы Төв банк Холбооны нөөцийн банкны своп шугамаар 84 хоногийн хугацаатай 94.5 тэрбум ам.долларын, 7 хоногийн хугацаатай 47.3 тэрбум ам.долларын санхүүжилтийг хийв.

БНХАУ | Хятадын Ардын банкнаас мөнгөний бодлогыг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах арга хэмжээнүүдийг авч байна. (i) 2-р сарын эхний хагаст 3 их наяд юанийн санхүүжилтийг банкны секторт олгов, (ii) зээл дахин санхүүжүүлэх, дахин хямдруулах шугамыг ашиглаж эрүүл мэндийн үйлдвэрүүдэд 800 тэрбум юанийн, бичил жижиг дунд бизнес эрхлэгчдэд 300 тэрбум юанийн, газар тариалангийн секторт 100 тэрбум юанийн бага хүүтэй зээлийн санхүүжилтүүдийг тус тус олгох, (iii) 7 болон 14 хоногийн хугацаатай сөрөх репо (reverse repo), 1 жилийн хугацаатай дунд хугацаатай зээлийн шугамын хүүг 10 суурь нэгжээр бууруулах, (iv) зорилтот сөрөх репо хүүг 50-100 суурь нэгжээр бууруулж хүртээмжтэй санхүүжилтийн нөхцөлийг жижиг бизнесүүдэд зориулан зөөлрүүлэн, хувийн ЖДҮ буюу хувьцаат компаниудын хүүг 100 суурь нэгжээр нэмж бууруулах, (v) бодлогын банкуудын зээлийг 350 тэрбум юаниар нэмэгдүүлж бичил, жижиг бизнесүүдэд олгох арга хэмжээнүүдийг авав. Мөн Засгийн газраас төлбөрийн хүндрэлд ороод байгаа айл өрх, компаниуд, бүсүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Хятадын ардын банктай хамтран хэрэгжүүлж байна. Үндсэн арга хэмжээнүүдээс дурдвал (i) зөвшөөрөгдсөн ЖДҮ эрхлэгчид, айл өрхүүдэд төлбөрийн болон зээлийн дэмжлэг үзүүлэх, (ii) цар тахлын нөлөөлөл бүхий салбаруудад чанаргүй зээлийн түвшин өсөхийг хүлцэх, (iii) актив удирдлагын шинэчлэлийг уян хатан хэрэгжүүлэх, (iv) орон сууцжуулах бодлогыг бүс нутгийн Засгийн газраар дамжуулж дэмжиж байгаа.

Их Британи | Английн Төв банкнаас хэрэгжүүлж байгаа үндсэн арга хэмжээнээс дурдвал: (i) бодлогын хүүг 65 суурь нэгжээр бууруулж 0.1% болгосон; (ii) Төв банкны мэдэлд буй ЗГҮЦ болон санхүүгийн бус компаниудын бондыг худалдаж авч 200 тэрбум фунт стерлингд хүргэв; (iii) бодлогын хүү буурсан нөлөөг дэмжих зорилгоор шинэ төрлийн хугацаат санхүүгийн схемийг нэвтрүүлж, бодит эдийн засагт ялангуяа ЖДҮ эрхлэгч нарт зээл олголтыг урамшуулах; (iv) Сангийн яам Төв банктай хамтран 330 тэрбум фунт стерлинг (ДНБ-ийн 15%)-ийн зээл, баталгааг олгох COVID-19 дэгдэлтийн улмаас хүндэрсэн компанийн санхүүжилтийн шугам, Коронавирусийн үед бизнесийн зээл тасалдахтай тэмцэх схемийг эхлүүлээ; (v) Болзошгүй алдагдлын хугацаат репо санхүүжилтийн шугамыг идэвхжүүлж, банкны одоо хэрэгжиж буй хөрвөх чадварын шугамыг дэмжих; (vi) Канад, Япон, Европ, АНУ, Швейцарын Төв банкуудтай хамтран ам.долларын своп шугамаар дамжуулан хөрвөх чадварыг сайжруулах; (vii) Их Британид хэрэгжиж буй мөчлөг сөрсөн буферийг 2%-аас бууруулж 2020 оны 12 сар гэхэд 0% болгож хамгийн багадаа 12 сар хадгална. Эдгээр бодлогын алхамтай уялдуулж Зохистой зохицуулалтын хорооноос банкуудыг ногдол ашиг болон бусад урамшууллыг өсгөхгүй байх талаар анхаарахаа мэдэгдэв.


Австрали | Австралийн нөөцийн банкны зүгээс 3-р сард бодлогын хүүг 2 удаа тус бүр 0.25 суурь нэгжээр бууруулж өдгөө түүхэн доод хэмжээ буюу 0.25%-д хүргээд байна. Түүнчлэн уг Төв банкнаас өгөөжийг барихын тулд 3 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах дээрээс худалдаж авч эхлэхээ зарлалаа. Мөн хөрвөх чадварыг хадгалахын тулд 1 болон 3 сарын хугацаатай репо арилжааг өдөр бүр 6 сар болон түүнээс дээш хугацаатай репо арилжааг долоо хоног тутамд зохион байгуулж байна. Холбооны нөөцийн банкны 60 тэрбум ам.долларын своп шугамыг нээж байгаагийн дээр Засгийн газрын дэмжлэгтэйгээр жижиг дунд бизнест зээл олголтыг дэмжиж хүүг бууруулахын тулд хадгаламжийн байгууллагуудад 3 жилийн хугацаатай санхүүгийн шугамыг нээгээд байна. Улмаар ЖДҮ эрхлэгчдэд 90 тэрбум Австрали долларын зээлийн эх үүсвэрийг бий болгов.

Эх сурвалж: www.imf.org/
POLICY RESPONSES TO COVID-19-
MONETARY AND MACRO-FINANCIAL

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ. ДОЛЛАРААР, 26/III ӨДРИЙН БАЙДЛААР)**



КОВИД-19 цар тахлын үед улс орнуудын авч хэрэгжүүлж буй төсвийн арга хэмжээ



Трүүчийн хуудсанд бид зарим улсуудын авч хэрэгжүүлээд байгаа мөнгөний бодлогын шийдвэр, арга хэмжээнүүдийг танилцуулсан. Тэгвэл энэ хэсэгт Ковид-19 цар тахлын эсрэг улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа төсвийн арга хэмжээнүүдийг тоймлолоо. Төсөв мөнгөний бодлогын шийдвэр гаргах процесс болон эдийн засагт бодит үр нөлөө гарах хугацаа нь харилцан адилгүй байдаг.

Эдгээр хоёр макро бодлогын уялдааг хангах шаардлага тулгарч байдаг ба төсвийн бодлогын хүрээнд ОУВС-ийн зүгээс 3 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар мэдээлсэн мэдээллийг хүргэж байна.



Австрали улс 2020 оны 3 дугаар сарын 24-ний байдлаар эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх хоёр багц арга хэмжээг батлаад байна. Энэхүү хоёр багцын нийт үнийн дүн нь 189 тэрбум ам.доллар (ДНБ-ий 9,7 хувь)-аар хэмжигдэх бөгөөд үүнд өрхүүдэд дэмжлэг үзүүлэх 25 тэрбум ам.доллар (ДНБ-ий 1.3 хувь), бизнес эрхлэгчдийг дэмжих 38.8 тэрбум ам.доллар (ДНБ-ий 2.0 хувь), болон эдийн засаг дахь зээлийн урсгалыг дэмжих 125

тэрбум ам.доллар (ДНБ-ий 6.4 хувь)-ийн санхүүжилтүүд багтсан байна. Зээлийн урсгалыг дэмжих санхүүжилтийн 20 тэрбум ам.доллар (ДНБ-ий 1.0 хувь)-ыг хамтын нөхөрлөлийн Засгийн газар ба оролцогч банкуудын хооронд байгуулсан зээлийн батлан даалтаар гаргах ба ЖДҮ-ийн хэрэгцээг нөхөх аж. Үүнд Австралийн Нөөцийн банкны 90 тэрбум ам.доллар (ДНБ-ий 4.6 хувь)-ын багц багтсан ба Төв банкны арга хэмжээг хассан эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсвийн багц нь 101.6 тэрбум ам.

доллар (ДНБ-ий 5.2 хувь) байна. Үүнээс гадна Засгийн газар нь урьдчилан таамаглах боломжгүй нөхцөлд зориулж 40 тэрбум ам.долларыг батлаад байна.



БНХАУ-ын Засгийн газраас тухай бүр арга хэмжээ авч, шат дараатай хөл хорио тогтоосон. Сүүлийн үед орон нутагт шинэ тохиолдлын тоо

буурч байгаа бөгөөд халдварт өвчинг буцааж импортлохгүйн тулд хилийн хориг тавив. Төсвийн бодлогын хүрээнд тус улс нь 2020 оны 3 дугаар сарын 23-ны байдлаар 1.3 их наяд юань (ДНБ-ий 1.2%-тай дүйцэх хэмжээний санхүүжилтүүдийг баталж, хэрэгжүүлж байна.

Тухайлбал, тархалтын аюулаас урьдчилан сэргийлж, хянах ажилд зарцуулах, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэлийг өсгөх, ажилгүйдлийн даатгалын төлбөрийг олгох зэрэг зардлыг нэмэгдүүлж, татвар болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөс чөлөөлөх арга хэмжээг авсан. Цаашлаад хөнгөлөлттэй зээлийн бодлого баримталж, Хубей мужийн жижиг бизнесүүдийн НӨАТ-ыг тэглэж, бусад мужуудын жижиг бизнесүүдэд 3-р сараас 5-р сарыг дуусталх хугацаанд НӨАТ-ыг 3 хувиас 1 хувь болгон бууруулав. Түүнчлэн, орон нутгийн дэд бүтцийн санхүүжилтэд зориулагдах Засгийн газрын тусгай зориулалттай бондын хэмжээг 2 сарын байдлаар 904 тэрбум юаньд хүргэж, өмнөх оны мөн үеэс 2 дахин нэмэгдүүлжээ.



ХБНГУ-ын Засгийн газар вирусийн тархалтыг хязгаарлахын тулд аяллын хязгаарлалт хийж, боловсролын

бүх байгууллагууд болон зайлшгүй үйл ажиллагаа явуулах шаардлагагүй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг түр зогсоох, олон нийтийн цугларалтыг хориглох зэргээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлээд байна.

Тэгвэл төсвийн чиглэлээр 156 тэрбум евро (ДНБ-ий 4.5 хувь)-тай тэнцэх зардал болон татварын үндсэн арга хэмжээнүүдийг баталж, хэрэгжүүлж байна. Үүнд: (i) эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хүчин чадал, судалгаа, шинжилгээний ажил (вакцин)-д зориулах зардал, (ii) ажлын байр, ажилчдын орлогыг хадгалах богино хугацааны ажлын («Курзарбэйт») татаас олгох боломжийг бий болгох, бага орлоготой эцэг эхчүүдэд хүүхэд асрах тэтгэмж олгох болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын дэмжлэгт хамрагдах боломжийг хялбар болгох зардал, (iii) Ковид-19 цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагаа нь хүндэрсэн жижиг бизнес эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд жилийн эцэс хүртэл хүү, торгуульгүйгээр татварыг нь хойшлуулахаас гадна 50 тэрбум еврогийн буцалтгүй тусламж олгох шийдвэрүүд багтаж байна. Үүний зэрэгцээ, шинээр байгуулагдсан Эдийн засгийн тогтворжуулах сан (WSF) болон Олон нийтийн хөгжлийн банкаар (KfW) дамжуулан зээл олголтыг дэмжих зорилгоор Засгийн газар 825 тэрбум еврогийн (ДНБ-ий 25%) зээлийн батлан даалтыг батлаад байна.



БНЭУ-ын Ерөнхий сайд Моди 3 дугаар сарын 24-нд улс даяар 21 хоногийн хөл хорио тогтоохоо мэдэгдсэн. Энэхүү мэдэгдлээс

өмнө, улс даяар вирусийн тархалтыг хязгаарлах зорилготойгоор харилцан адилгүй олон арга хэмжээнүүд авч байсан бөгөөд үүнд аяллын хязгаарлалт (олон улсын арилжааны зорчигч тээврийн онгоцны нислэгийг бүрэн хязгаарлах, дотоодын зорчигчийн агаарын хөдөлгөөнийг цуцлах зэрэг зарим хязгаарлалт орно); боловсролын бүх байгууллагууд, музей, театруудыг хаах; олон нийтийн цугларалтад хориг тавих болон зайнаас ажиллахыг дэмжих.

Ерөнхий сайд Моди 150 тэрбум рупи (ДНБ-ий 0.1 орчим хувь)-ийг эрүүл мэндийн дэд бүтцэд зориулна гэж мэдэгдэв. Үүнийг Коронавирусийн шинжилгээ авах байгууламж, хувийн хамгаалалтын хэрэгсэл, тусгаарлах ор,

агааржуулагч худалдаж авахад зарцуулна гэж мэдэгдсэн байна.

Мужийн түвшинд зарим идэвхжүүлэх арга хэмжээг зарласан бөгөөд хамгийн том хэмжээтэй нь Керала мужид 200 тэрбум рупигийн багц (мужийн ДНБ-ий 2.5 хувь; Энэтхэг улсын ДНБ-ий 0.1 хувь) баталсан байна. Үүнд мөн орлогын түвшин доогуур өрхүүдэд мөнгөн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ багтсан. Төв Засгийн газар одоо байгаа Хөдөлмөр халамжийн зөвлөлийн сангаас үйлдвэрчний эвлэлд багтаагүй барилгын ажилчдад шууд мөнгөн дэмжлэг үзүүлэхийг мужийн Засгийн газруудад уриалав.

Улсын хэмжээнд татварын мэдүүлэг болон бусад дагаж мөрдөх хугацааг хойшлуулах зэргээр татварын дарамтыг хөнгөвчлөхөө зарласан. Засгийн газар Коронавирусийн тархалтын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсэг нь нэмэлт төсвийн болон эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдийг санал болгох аж.



Тахлын голомт болоод байгаа Итали Улсын Засгийн газар вирусийн тархалтыг хязгаарлахын тулд хатуу арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсээр

байна. 3 дугаар сарын эхээр улс даяар дөрвөн долоо хоногийн хөл хорио тогтоож, аялал жуулчлалыг хязгаарлаж, олон нийтийн цугларалтыг хориглосон. Бүх сургууль, их дээд сургуулиудыг хаасан байна. Супермаркет болон хүнсний дэлгүүр, эмийн сан, банк, нийтийн тээврийн үйлчилгээ, зайлшгүй хэрэгцээтэй нийтийн үйлчилгээ болон бусад үйлчилгээнээс бусад үйл ажиллагааг 4 дүгээр сарын эхэн хүртэл хаасан байна.

Засгийн газраас нь 25 тэрбум еврогийн (ДНБ-ий 1.4 хувь) яаралтай тусламжийн багц баталсныг дэлгэрүүлбэл, (i) Италийн эрүүл мэндийн болон иргэний хамгааллыг тогтолцоог бэхжүүлэх хөрөнгө (3.2 тэрбум евро); (ii) ажлын байр хадгалах, ажилгүй болсон болон хувиараа

хөдөлмөр эрхэлдэг иргэдийн орлогыг дэмжих (10.3 тэрбум евро), (iii) бизнес эрхлэгчдийг дэмжих бусад арга хэмжээ, үүнд татварын төлөлтийг хойшлуулах, хамгийн их өртсөн хотуудад ашиглалтын төлбөр хойшлуулах (6.4 тэрбум евро), түүнчлэн (iv) аж ахуйн нэгж болон айл, өрхүүдэд олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх (5.1 тэрбум евро) санхүүжилт, батлан даалтыг баталж, 350 орчим тэрбум еврогийн (ДНБ-ий 20 хувь) зээл олгох бололцоог бүрдүүлжээ.



Эрх баригчид 2-р сарын 13-нд онцгой дэглэм зарлаж, өндөр эрсдэлтэй улс орнууд руу аялахыг хориглох,

Хятад Улс руу нүүрс экспортлохыг түр зогсоох, нийгмийн алслалт, олон нийтийн арга хэмжээг цуцлах, сургууль, их сургуулийн үйл ажиллагааг хаах зэрэг өргөн хүрээний арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлсэн. Төсвийн хүрээнд 2020 оны 3 дугаар сарын 24-ний байдлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс дурдвал эрүүл мэндийн салбарт нэмэлтээр 12 тэрбум төгрөгийг (ДНБ-ий 0.03 хувь) баталж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, эмнэлгийн хангамж, эмнэлгийн ажилчдын илүү цагийн цалинг олгоход зарцуулсан байна. Энэхүү зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргасан болно.

Төсвийн нэмэлт арга хэмжээнүүд зарлагдаж, 4 дүгээр сарын эхээр парламентын чуулганаар хэлэлцэж, батлахаар хүлээгдэж байна. Үүнд: (i) импортын хүнсний зарим бараанд татварын хөнгөлөлт үзүүлэх; (ii) супермаркет, худалдаа, үйлчилгээний төвүүд түрээсээ бууруулсан тохиолдолд татварын хөнгөлөлт үзүүлэх; (iii) гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд татвар болон хоцорсон төлөлтийн торгуулиас чөлөөлөх; (iv) ЖДҮ-д чиглэсэн зээлийн батлан даалтыг нэмэгдүүлж, Хөгжлийн банкнаас ноолуурын үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох хүлээлттэй байна.

Эх сурвалж: <https://www.imf.org/>
POLICY RESPONSES TO COVID-19-



1230-аад оны үед цаасан мөнгийг дэлхий дээр монголчууд анх удаа хэрэглэж эхэлсэн ба энэ нь хүн төрөлхтний нийгэм, эдийн засгийн харилцаанд үндсэн томоохон эргэлтүүдийг гаргасан нь хэдийнээ түүхэнд бичигдэн үлдсэн байдаг. Алт, мөнгө, адуу малыг цаасан мөнгөөр сольсон нь тухайн үед гайхалтай хувьсгалт зүйл байсан.

Тэгвэл өнөөдөр XXI зууны техник, технологийн дэвшил цаасан мөнгөний хэрэглээг улам бүр багасгасаар зарим улс орон цаасан мөнгөгүй эдийн засагт (cashless economy) шилжих чиглэл барин явж байна. Бид төлбөр тооцоогоо карт, ухаалаг утас, чип ашиглан хийх болсон нь энэ үеийн гайхалтай хувьсгалт зүйл болж байна.

Цахим төлбөр тооцоо гэж юу вэ?

Энгийн жишээн дээр тайлбарлая. Та дэлгүүрээс бараа бүтээгдэхүүн авахдаа бэлэн мөнгө, аль эсвэл бэлэн бус аргаар төлдөг. Цахим төлбөр тооцоо гэдэг нь та өөрийн авсан бараа бүтээгдэхүүн,

үйлчилгээний төлбөрийг бэлэн мөнгөөр бус өөрийн банкны данснаасаа карт, ухаалаг утас, чип ашиглан төлөхийг хэлнэ.

Дээр дурдсанчлан дэлхийн зарим улс орон цаасан мөнгөгүй эдийн засаг руу шилжиж байна. Жишээ нь: Дани, Норвеги зэрэг улсууд цахим төлбөр тооцооны хэрэглээгээрээ дэлхийд тэргүүлэгч улс орнуудын тоонд зүй ёсоор орно. Швед улсын хувьд нийт төлбөр тооцооны 15% нь л бэлэн буюу цаасан мөнгөөр хийгдэж байна. Швед болон Их Британид хүнсний дэлгүүрүүд, нийтийн тээвэр нь бэлэн мөнгө авахаа больсон. Шведийн мөн Их Британийн арилжааны банкууд бэлэн мөнгөөр гүйлгээ хийхээс татгалзан өөрсдийн банкны ATM машинуудыг хурааж эхэлсэн байна¹.

Хятадулснь цахим төлбөр тооцооны хэрэглээгээрээ мөн дэлхийд толгой цохидог улсын нэг. Хятад улс бэлэн мөнгөөс татгалзахаас гадна төлбөрийн картын хэрэглээг мөн багасгаж байна. Европын орнуудад контактлесс төлбөр тооцоог (contactless

¹ <https://www.nayax.com/first-cashless-country/>

ЦАХИМ ТӨЛБӨР ТООЦООНЫ ХЭРЭГЛЭЭ

2006 онд Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд банк хоорондын төлбөр тооцооны гүйлгээг их дүнтэй, бага дүнтэй гэж ангилан Төлбөр тооцооны төвөөр дамжуулан гүйцэтгэж эхэлсэн. Мөн 2010 онд тус төвөөр дамжуулан картын гүйлгээний банк хоорондын төлбөр тооцоог хийх болсоноор картын свитчийн систем нэвтэрсэн³.

Монголбанкны 2018 оны жилийн тайлангаас харахад төлбөрийн картын хэрэглээ 2017 онтой харьцуулахад 11,6%-иар өссөн. Эдгээр картанд зориулсан ПОС терминал 2018 онд өмнөх онтой харьцуулахад 53,9%, АТМ 16,1%-иар тус тус өссөн байна⁴. 2018 онд эдгээр төхөөрөмжүүдээр дамжуулан хийсэн гүйлгээний дүн 2017 онтой харьцуулахад 35,7%-иар өссөн үзүүлэлттэй гарчээ. Үүнээс харахад Монголд цахим төлбөр тооцооны хэрэглээ өсч, иргэд бэлэн бус төлбөр тооцоог илүүд үздэг болсон нь харагдаж байна.

Төв банкны тухай хуулийн дагуу төгрөгийг орлох төлбөрийн бусад хэрэгслийн зөвшөөрлийг Монголбанк олгодог. Одоогоор Монголбанкны зөвшөөрөлтэй төгрөгийг орлох хоёр хэрэгсэл байгаа нь төлбөрийн карт болон цахим мөнгө юм. Монголбанк анхны цахим мөнгө гаргах үйл ажиллагааны зөвшөөрлийг Мобифинанс ББСБ-д 2018 онд олгосон ба уг цахим мөнгөн нь “Candy” гэх нэршилтэй.⁵

Монголбанкнаас 2018 онд хийгдсэн томоохон ажлуудаас онцолбол 1 сая төгрөг хүртлэх бэлэн бус гүйлгээг бодит цагийн горимд хийдэг байсан бол төлбөр тооцооны системд шинэчлэл хийснээр энэхүү дүнг өсгөж 3 сая хүртлэх төгрөг болгосон. Ингэснээр харилцагчид банкны салбарт заавал биеэр очих шаардлагагүй болж интернет банк, мобайл банк, гар утасны аппликейшнууд ашиглан 3 сая хүртэлх төгрөгийг банк хооронд шилжүүлэхэд хоног хугацаа алдана гэж санаа зовоох шаардлагагүй болсон. 2019 онд Монгол улс банк хоорондын бага дүнтэй гүйлгээний системийг сольж, АСН+ систем нэвтрүүлснээр

payment) ихээр ашиглаж байгаа бол Хятад улс QR кодыг ашиглаж байна. Алибаба компанийн Алипэй болон гар утасны ВиЧат аппликейшнууд нь цахим төлбөр, тооцооны гол хэрэгсэлүүд юм. Хятадад хаа сайгүй QR кодоор төлбөр тооцоогоо хийдэг дэлгүүрүүд, үйлчилгээний газрууд байдаг. Сүүлийн үед Хятад улсын иргэд үндэсний баяраараа бэлэн мөнгө бэлгэнд өгөхийн оронд QR код агуулсан дугтуйг бэлэглэдэг болсон нь үнэхээр сонин, гайхалтай ч юм шиг.

Монгол улсын хувьд 1997 онд Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн системд мэдээллийн технологийн давуу талд суурилсан шинэ програм хангамж ашиглаж, банк хоорондын тооцоонд багц файлын хэлбэрийг нэвтрүүлснээр баримтаар буюу цаасаар хийдэг банк хоорондын төлбөр тооцооны ажиллагааг халж, Төв банкин дахь банкуудын харилцах дансаар дамжуулан банк хоорондын төлбөр тооцоог гүйцэтгэх болсон нь төлбөрийн системийн хөгжилд шинэлэг алхам болсон².

² <https://www.mongolbank.mn/listpaymentsystem.aspx>

³ <https://www.mongolbank.mn/listpaymentsystem.aspx>

⁴ Монголбанкны 2018 оны жилийн тайлан, 40-41 хуудас

⁵ Монголбанкны 2018 оны жилийн тайлан, 39 хуудас

хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдал, нууцлал сайжирч, төлбөрийн системийн үр ашиг нэмэгдэж, гүйлгээний хугацаа багассан зэрэг олон ач холбогдолтой.

Үндэсний ₮ карт манай иргэдийн дотоод төлбөр тооцоондоо өдөр тутам, хамгийн өргөн хэрэглэдэг төлбөрийн хэрэгсэл. Монголбанк үндэсний төлбөрийн ₮ картыг шинэчлэх, чиптэй болгох, цаашлаад зайнаас уншдаг технологид шилжүүлэх

зэрэг ажлыг эхлүүлээд явж байна. Өмнө нь данс нээх, зээл авах, хадгаламж байршуулах, төлбөр төлөх, картаа удирдах, дансны тодорхойлолт, хуулга авах гэсэн шалтгаанаар харилцагчид банкинд очдог байсан бол одоо дийлэнх нь зөвлөгөө авах гэж ханддаг болсон. Монгол улсын банкны салбарын хөгжил олон улсын түвшин рүүгээ ойртож, санхүүгийн зөвлөгчийн үүргээ хэрэгжүүлж эхэлж байна.



АЛИВАА ЮМ БҮХЭН ХОЁР ТАЛТАЙ

Цахим төлбөр тооцооны давуу талуудыг дурдвал

- Эдийн засаг дахь мөнгөний эргэлтийн хурдыг нэмнэ.
- Бэлэн мөнгөтэй холбоотой хулгай дээрмийн хэрэг буурна. Эдийн засаг дахь мөнгөний эргэлт “шилэн” болно. Ингэснээр татвараас зугтах гэх мэт сөрөг үзэгдэл буурч, цаашлаад авилгатай тэмцэх үйл хэрэгт түлхэц болно.
- Бэлэн мөнгө хэвлүүлэх, тээвэрлэх, хадгалах гэх мэт зардал буурна.
- Цаг хугацаа хэмнэнэ. Бид цаг хугацааг алттай зүйрлэдэг. Энэ эрин үед цахим төлбөр тооцоог ашигласнаар түргэн шуурхай үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний худалдан авалтыг, байр, утасны төлбөрөө ч ажлынхаа дундуур, гэртээ амарч байхдаа гээд ажлын цагаас үл хамааран төлөх боломжуудыг бидэнд олгож байна.
- Их хэмжээний мөнгө биедээ авч явах тохиолдолд хаа нэгтээ хаях, үрэгдүүлэх, дээрэмдүүлэх гэх мэт асуудлыг ор тас мартаж болно.
- Зөвхөн Монголд ч биш бид аялж явахдаа ч Дэлхийн хаанаас ч дурын төлбөр, тооцоогоо гар утсаа ашиглан хийдэг боломжтой үед амьдарч байна.

Цахим төлбөр тооцооны сөрөг талууд нь:

- Цахим төлбөр тооцооны нэг дутагдалтай тал нь тухайн улсын иргэн болгон интернетгүй, ухаалаг утасгүй, тэдгээр нь байсан ч тодорхой хэмжээний мэдлэг дутмаг байдаг. Үүнээс болж “cashless economy” руу шилжих процесс удаашрах магадлалтай.
- Төлбөр тооцоо цахим хэлбэрт шилжсэнээр цахим луйвар, цахим халдлага гэх мэт гэмт хэргийн тоо өсөх магадлалтай. Кибр аюулгүй байдал, хамгаалалт маш хатуу, чанга байхгүй бол хакерууд энэ л сиймхийг ашиглаж ажиллана.
- Өвгөд, хөгшид болон ядуу иргэд цахимжсан нийгэмд учраа олохгүй, самгардах байдал дэлхийн хаана ч тохиолдож байна.

Манай улсын хувьд Төв банкнаас төлбөрийн системийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, шинээр нэвтрүүлж буй техник, технологийн тусламжтайгаар дэлхийн улс орнуудтай эн зэрэгцэн алхаж, дэлхийн хөгжлийг цаг алдалгүй даган “cashless economy” руу алхаж яваа улсын нэг. Ганц Төв банк гэлтгүй банк, санхүүгийн байгууллагууд, үүрэн телефоны операторууд цахим төлбөр тооцооны хөгжилд өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.

МОНГОЛБАНК БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ТУХАЙ БҮРТ НЬ АВЧ ХЭРЭГЖҮҮЛНЭ



Covid-19 цар тахалтай холбоотойгоор нийтээр мөрдөж буй хязгаарлалт, хорио цээрийн дэглэм нь зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, улмаар тухайн аж ахуйн нэгжүүд болон иргэдийн мөнгөн орлого тасалдаж, төлбөрийн чадвар муудаж, банкнуудаас авсан зээлийг гэрээний дагуу төлөхөд хүндрэл үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор давхардсан тоогоор 26 мянган зээлдэгчийн 2.5 их наяд төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсээд байна. Үүнээс 65.1% нь буюу 2.0 их наяд төгрөг нь аж ахуйн нэгжид, 35.0% нь буюу 545 тэрбум төгрөг нь иргэнд тус тус хамаарч байна. Мөн хуваарийн дагуу хийгдэх ёстой нийт өрийн үйлчилгээнээс 195 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 72 тэрбум төгрөгийн хүү төлөгдөөгүй байна.

Монголбанкнаас Covid-19 цар тахлын банк, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөг бууруулахад шаардлагатай боломжит арга хэмжээг бусад улс орнуудын туршлага болон банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр арга хэмжээ нь зөвхөн мөнгөний бодлогын арга хэрэгслээр хязгаарлагдахгүй, макро-зохистой бодлого болон хяналт шалгалтын хүрээнд банкнуудад мөрдүүлдэг зарим нэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг түр хугацаанд уян хатан байдлаар өөрчлөн тогтоох арга хэмжээг хамаарууллаа. Мөнгөний бодлогын хорооны

2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэр гаргасан. Ингэснээр банкнууд санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, банк хоорондын захын хүүгийн хэлбэлзлийг сааруулах, банкнуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх боломж бүрдлээ. Эдгээр багц арга хэмжээний дүнд банкнууд зээлийн хүү 1 нэгж хувиар буурах, зах зээлд хамгийн багадаа 300-400 тэрбум төгрөгийн зээл шинээр гарах боломжтой гэсэн урьдчилсан тооцоо гарч байна.

Банкнуудад мөрдүүлж буй “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаанд өөрчлөлт орууллаа. Тухайлбал, зээлдэгчдийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй, дордуулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкнуудад олгоод байна.


МОНГОЛБАН

Өөрөөр хэлбэл, Covid-19 цар тахалтай холбоотойгоор хөл хорио тогтоосноор зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлж байна. Түүнчлэн, банкнуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулах, өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх арга хэмжээг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргаснаар банкнуудын санхүүгийн чадавхад эерэг нөлөө үзүүлэх боломж бүрдлээ.

Арилжааны банкнууд Монголбанкнаас гаргасан багц шийдвэрийн дагуу холбогдох дотоод журам, дүрэмдээ өөрчлөлт оруулан харилцагчийн

хүсэлтээр зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг эхлүүлснээр 1,069 иргэдийн 36.6 тэрбум төгрөгийн зээл, 126 байгууллагын 409.8 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд хөнгөлөлт үзүүлээд байна. Хэрэв зээлдэгч хорио цээрийн дэглэмтэй холбоотойгоор зээлийн үндсэн төлбөр, хүүгээ хуваарьт заасны дагуу төлж чадахгүй нөхцөл үүсэн бол өөрийн үйлчлүүлдэг банканд хандан гэрээндээ нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой юм.

Монголбанк цар тахал хэдий хугацаанд үргэлжлэх, санхүүгийн салбар болон бодит секторт үзүүлэх нөлөөлөл хэрхэн өөрчлөгдөж байгаагаас шалтгаалан Засгийн газар, холбогдох яам, мэргэжлийн байгууллагатай хамтран бодлого, зохицуулалтын арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх болно.



Монголбанкнаас



Ковид-19 цар тахлын үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

2020.04.03

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн зээлийн эргэн төлөлтийг түр хойшлуулав



Зээлийн эргэн төлөлтөд нь 2020.01.31-ний өдрөөс хойш доголдол үүссэн **8% болон 5%-ийн** ипотекийн зээлтэй иргэдийн **зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж**, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах боломжийг нээлээ.

2020.04.01

Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулав



2020.04.01-ний өдрөөс эхлэн гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд банк хоорондын **бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг 20%-100% буурууллаа**. Энэхүү шийдвэр нь иргэдийг цахимаар төлбөр тооцоогоо хийхийг дэмжих зорилготой.

2020.03.25

Төв банкнаас банкинд олгох барьцаат зээлийн журамд түр өөрчлөлт оруулав



Банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банкинд олгох барьцаат зээлийн журамд **2020.07.31-ний өдөр хүртэл** түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр Төв банкнаас банкинд олгох барьцаат зээлийн **хугацааг 180 хоног болгон уртасгаж, хүүг 11%-д бууруулав**.

2020.03.18

Зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацааны өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэв



Хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг **"Хэвийн" зээлийн хувьд 90 хүртэлх хоног болгон өөрчилж, зээлийн бүтцийг өөрчлөх буюу холбогдох зээлийн гэрээний нөхцөл, хуваарьт өөрчлөлт оруулах** боломжийг банкуудад олгов.

2020.03.11


Төгрөгийн заавал байлгах нөөц (ЗБН)-ийг 2 нэгж хувиар бууруулав



Банкууд төвлөрүүлсэн хадгаламжийнхаа тодорхой хувийг Төв банканд болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд байршуулдаг. Төгрөгийн ЗБН-ийг бууруулснаар банкуудад **324 тэрбум төгрөгийн** эх үүсвэр чөлөөлөгдөж, **зээл хэлбэрээр гарах боломж нэмэгдэх бөгөөд төгрөгийн хадгаламж татах сонирхол нэмэгдэж, долларжилт буурахад нөлөөлнө**.

2020.03.11


Хүүгийн коридор системийг шинэчилж, +/- 1 нэгж хувиар тогтоов



Энэхүү шийдвэр нь банк хоорондын захын хүүгийн хэлбэлзлийг бууруулах замаар **бодлогын хүүний нөлөөг нэмэгдүүлэх**, банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх нөлөөтэй.

2020.03.11


Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 10 хувь болгов



Эдийн засгийн **өсөлт саарах** хандлага үргэлжилж, **инфляци тогтвортой байх** төлөвтэй байгаа тул бодлогын хүү 11% байсныг 1 нэгж хувиар буурууллаа. Энэ нь санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийн идэвхжилийг дэмжихэд эергээр нөлөөлнө.




50 Төгрөгийн сайжруулсан дэвсгэртийн хамгаалалтын таних тэмдгүүд



ШИНЭ

Усан хээ

Гэрлийн эсрэг барихад тод харагдах Чингис хааны хөрөг болон МБ гэсэн үсэгтэй усан хээг сайжруулсан.



Давхцаж харагдах дүрс


Дэвсгэртийн нүүр болон ард талд байрлах Чингис хааны Гэрэгэ дэх дугуй дүрсүүд зөрүүгүй давхцана.



ШИНЭ

Өнгө нь хувирагч элемент

Баруун доод булан дахь хээн дээр байрлуулсан 50-ын тоо нь 3 хэмжээстэй бөгөөд дээш, доош налуу хөдөлгөөд цаад гүн хэсэгт шар болон ногоон өнгийн цагирагнууд ээлжлэн солигдож харагдана.



ШИНЭ

Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан элемент

Баруун, зүүн ирмэг дэх 2 ширхэг ташуу товгор зураас нь 50-тын дэвсгэртийг илэрхийлэх бөгөөд хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.




Товгор элемент

- МОНГОЛУЛСГэсэнэвхматмонголбичиг,
- Сүхбаатарын хөрөг болон хөрөгний ар талын фон,
- 50 -ын араб болон уйгаржин тоо,
- Гарын үсэг,
- Монголбанк, тавин төгрөг гэсэн уйгаржин монгол бичилтүүд нь хурууны үзүүрт тэмтрэгдэнэ.



Далд элемент

Дэвсгэртийг налуу барихад 50-ын араб болон уйгаржин тоо харагдана.



Тасралттай металл тууз

Туузыг гэрлийн эсрэг барихад MONGOLBANK гэсэн бичиг харагдана.



WWW.MONGOLBANK.MN